



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 12

- Монгол Улсын 1998 оны төвлөрсөн төсвийн тухай Монгол Улсын хууль
- Ажлын таван өдөртэй долоо хоногт шилжүүлэх тухай Монгол Улсын хууль
- Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай Монгол Улсын хууль



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Хэвлэл

№ 1997 оны 12-р сар №12 /67/

ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1099
2.	Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1105
3.	Захиргааны харуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1106
4.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай	1106
5.	Гэрээ соёрхон батлах тухай	1114
5.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай	1115
7.	Конвенцид нэгдэн орох тухай	1116
8.	Хуульд өөрчлөлт оруулах тухай	1116
9.	Монгол Улсын 1998 оны төвлөрсөн төсвийн тухай	1117
0.	Гэрээ соёрхон батлах тухай	1119
1.	Ажлын таван өдөртэй долоо хоногт шилжүүлэх тухай	1119
2.	Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1120

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

3.	Хуулийн төсөл буцаах тухай №84	1121
4.	Байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, гишүүнээр батлах тухай №85	1121
5.	Тогтоолын төсөл буцаах тухай №86	1122
6.	"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1998 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл"-ийг батлах тухай №87	1122
7.	Төрөөс мөнгөний бодлогын талаар 1998 онд баримтлах үндсэн зарилт, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай №88	1148
8.	Хуулийн төслийг санаачлагчид нь буцаах тухай №90	1151
9.	Хуулийн төсөл буцаах тухай №91	1152
0.	Тогтоолын төсөл буцаах тухай №92	1152
1.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №93	1153

3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

22.	МУИС-ийн зарим багшид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай №61	115
23.	С.Цэвэлмаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай №62	115
24.	Д.Сүхэд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай №63	115
25.	МУИС, Хөгжим, бүжгийн коллежийн зарим багшийг одон, медалиар шагнах тухай №64	115
26.	Н.Бүтэнбаярыг "Алтэн гадас" одонгоор шагнах тухай №65	115
27.	Т.Нармандахыг Цэргийн гавьяаны одонгоор нэхэн шагнах тухай №66	115
28.	Л.Шижирболдыг Цэргийн хүндэт медалиар шагнах тухай №67	115
29.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тухай №68	115
30.	Р.Самжидад Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай №69	115
31.	Ц.Батнасанд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай №70	115
32.	А.Дүмбурай, М.Лхамсүрэн шарыг Сүхбаатарын одонгоор шагнах тухай №71	116
33.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай №72	116
34.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай №73	116
35.	С.Хундмаад Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээх тухай №75	116
36.	Д.Волоожид Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээх тухай №76	116
37.	Хөдөө аж ахуйн салбарын зарим хүнийг одон, медалиар шагнах тухай №77	116

4. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

38.	Ой тэмдэглэх тухай №213	116
39.	Син байгуулах тухай №219	116
40.	Хөтөлбөрт зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай №220	117
41.	Журам батлах тухай №221	117
42.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай №225	117
43.	"Тогтвортой байдлын гэрээ"-ийг залуур батлах тухай №226	117
44.	Хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай №229	118
45.	С.Магсаржавын ой тэмдэглэх тухай №230	118
46.	Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай №233	118
47.	Журам батлах тухай №234	118
48.	Нүүрсний уурхайнуудын лицензийг шинэчлэн олгох тухай №235	118

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдалын тухай хуульд дор дурдсан агуулгатай 11¹ дүгээр зүйл, 19 дүгээр зүйлийн 5, 22 дугаар зүйлийн 5,6 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 8,9 дэх хэсгийг тус тус нэмсүгэй:

1/11¹ дүгээр зүйл:

"11¹ дүгээр зүйл. Гадаадын иргэлийн иргэний гэр бүлийн байдалын бүртгэл

Гадаадын иргэнд холбогдсон иргэний гэр бүлийн байдалын бүртгэлийг нийслэлд Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв, аймагт аймгийн Засаг даргын Тамгын газар эрхлэн явуулна."

2/19 дүгээр зүйлийн 5 дахь залт:

"5/Монгол Улсад амьдрах, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй бол."

3/22 дугаар зүйлийн 5,6 дахь хэсэг:

"5. Монгол Улсын харьяат иргэнтэй гэр бүл болсон бөгөөд 90 хоногоос дээш хугацаагаар Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэнийг байнга оршин суугч гэнэ.

6. Монгол Улсад хувийн хэргээр 90 хоногоос 5 жил хүртэл хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч гэнэ."

4/26 дугаар зүйлийн 8,9 дэх хэсэг:

"8. Монгол Улсад зорчигч, дамжин өнгөрөгч, хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхээр зорчигч гадаадын иргэний бүртгэлийг Хиалийн цэргийг удирдах газар, хяналтыг Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага зохион байгуулж холбогдох байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангана.

9. Гадаадын иргэнтэй холбоотой бүх төрлийн мэдээг холбогдох төрийн захиргааны байгууллагууд Зөвлөлд тогтоосон хугацаанд ирүүлж байна."

2 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдалын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 14, 15, 16 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 2,3,4 дэх хэсэг, 23, 24 дүгээр зүйл, 25 дугаар зүйлийн 1,2,3 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 1,3,6 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/11 дүгээр зүйл:

"11 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэх

1. Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв буюу түүний эрх олгосон байгууллагын зөвшөөрөлтэйгээр энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар хориглосноос өөр ажил, албан тушаал эрхлэх, гадаадын байгууллагад ажиллах, аж ахуйн нэгж байгуулан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж болно.

2. Монгол Улсад Засгийн газар хоорондын болон эрх бүхий байгууллагын гэрээний үндсэн дээр ажил, албан тушаал эрхэлж, суралцаж байгаа, түүнчлэн төрийн бус болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар ажиллаж байгаа гадаадын иргэн гэрээний хугацаа дууссан буюу хугацаанаас өмнө гэрээгээ цуцалсаны дараа хүсэлт гаргавал уг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр өөр аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулан ажиллаж, суралцаж болно.

3. Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч болон байнга оршин суугч, цагаачаас бусад гадаадын иргэн ирсэн зорилгоосоо гадуур орлого олохоор хувиараа буюу аж ахуйн нэгж, байгууллагад ажил, албан тушаал эрхэлж болохгүй.

4. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа аж ахуйн аливаа нэгж, байгууллага, иргэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв буюу түүний эрх олгосон байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээ байгуулж болно."

2/12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бод Монгол Улсад зорчих гадаадын иргэн Монгол Улсын виз /цаашид "виз" гэнэ/ авсан байна.

3/13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх олгосноор Хилийн цэргийг удирдах газар, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, Монгол Улсын өргөмжит консул виз олгож болно."

4/14 дүгээр зүйл:

"14 дүгээр зүйл. Виз олгох байгууллагын эрх, үүрэг

1. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага виз олгох талаар дараахь эрх, үүрэгтэй:

1/бүх төрөл, зориулалт, зэрэглэлийн виз олгох;

2/олгогдсон визийн төрөл, зориулалт, зэрэглэлийн үндэслэлийн хянаж өөрчлөх;

3/виз олгохоос татгалзах, түүний хугацааг богиносгох, сунгах, олгосон визийг хүчингүй болгох;

4/Монгол Улсын хилийн олон улсын зорчигч, тээврийн зэрэгслийн харилцааны нээлттэй боомт дээр виз олгох зөвшөөрлийг ирх бүхий байгууллагад өгөх;

5/Монгол Улсын визийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх;

6/виз олгох үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах.

2.Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв виз олгох талаар дараахь эрх, үүрэгтэй:

1/Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, арьялалгүй хүнд гарах, гарах-орох виз олгох;

2/хууль тогтоомжид заасан үндэслэл байвал виз олгохоос татгалзах, олгосон визийг хүчингүй болгох;

3/Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, арьялалгүй хүнд олгосон визийн нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.

3.Хилийн цэргийг удирдах газар виз олгох талаар дараахь эрх, үүрэгтэй:

1/Монгол Улсын олон улсын зорчигч, тээврийн хэрэгслийн харилцааны нээлттэй хилийн боомт дээр Монгол Улсад зорчигчдоо орох-гарах, дамжин өнгөрөх, зайлшгүй шаардлагатай тохнолдод гарах виз олгох;

2/хууль тогтоомжид заасан үндэслэл байвал виз олгохоос татгалзах;

3/олгосон визийн бүртгэл хөтлөх.

4.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх олгосноор Монгол Улсын өргөмжт консул Монгол улсад орох, орох-гарах, дамжин өнгөрөх виз олгож болно."

5/15 дугаар зүйл.

"15 дугаар зүйл. Виз олгох үндэслэл

1.Монгол Улсад албан хэргээр зорчих гадаадын иргэнд дараахь үндэслэлийн аль нэг нь байвал виз олгож болно:

1/Монгол Улсын төрийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах байгууллага, Улсын Их Хуралд суудал бүхий яамын урилгатай бол;

2/Монгол Улсад суугаа гадаадын дипломат төлөөлөгчийн болон онсуудын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн айгууллагын суурин төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэд, эдгээрийн гэр бүлийн гишүүний талаар тухайн газар байгууллагыг арьяадах улс, олон улсын байгууллагын албан ёсны хүсэлт, Монгол Улсын олон улсын гэрээний заалттай бол;

3/Монгол Улсад Засгийн газар хоорондын гэрээгээр хөдөлмөр рхлэх, суралцах түүнчлэн гадаадын төрийн бус болон олон улсын айгууллагын төлөөлөгчийн газар, гадаадын хөрөнгө оруулалттай аж хүйн нэгжийн удирдах бүрэлдэхүүнд ажиллахаар ирэх гадаадын иргэний хувьд гэрээ, тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны эрх байгууллагын зөвшөөрөлтэй бол;

2. Монгол Улсад хувийн хэргээр зорчих гадаадын иргэнд дараахь үндэслэлийн аль нэг нь байвал виз олгож болно:

1/Монгол Улсад оршин суух, буцаж явах хөрөнгийн эх үүсвэртэй бөгөөд түүнийгээ нотолсон баталгааг тухайн гадаадын иргэнээс буюу Монгол Улсад хүлээн авах байгууллага, иргэнээс гаргасан бол;

2/Монгол Улсад хувийн хэргээр байнга оршин суух гадаадын иргэнд Монгол Улсын хууль болон олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрөгдсөн гэрлэлтийн гэрчилгээтэй бол;

3/аалян жуулчлах, эмчлүүж сувилуу, гадаадад оролцох, гачигдал зэргээр ирэх тохиолдолд хөлбогдох гэрээ үзүүлж, Монгол Улсын хүлээн авах байгууллагын зөвшөөрөлтэй бол;

4/ажил, албан тушаал эрхлэх, эрдэм шинжилгээний ажил хийх болон суралцах зорилгоор гадаад орноос ирэх хүмүүсийн хувьд тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэй бол;

5/энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1,3,4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний хүсэлтээр нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, аймагт цагдаагийн байгууллагаас зөвшөөрч олгосон урилгатай бол;

3. Монгол Улсад цагаачлах гадаадын иргэнд дараахь үндэслэл байвал виз олгоно:

1/Монгол Улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй бол;

2/тухайн хүн Монгол Улсад оршин суух хөрөнгийн эх үүсвэртэй бөгөөд түүнийгээ нотолсон баталгааг гаргасан бол.

4. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад зорчигч гадаадын иргэнд урилгагүйгээр виз олгож болно."

6/16 дугаар зүйл:

"16 дугаар зүйл. Визийн хугацаа

1. Монгол Улсын визийг дөр дүртэй хугацаагаар олгоно:

1/Монгол Улсад зорчигч гадаадын иргэнд орох-гарах шонийг 30 хүртэл хоног;

2/Монгол Улсад түр оршин суугч гадаадын иргэнд 90 хүртэл хоног;

3/олон удаагийн визийг 6, 12 сар;

4/гарах визийг 30 хүртэл хоног;

5/дамжин өнгөрөх визийг 7 хүртэл хоног;

6/Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьталаагүй хүнд гарах-орох визийг 90 хүртэл хоног.

2. Монгол Улсад зорчигч болон түр оршин суугч гадаадын иргэнд олгосон визийн хугацааг нэмэгдэл 30 хүртэл хоногийн хугацаагаар өргөж болно."

7/17-дугаар зүйлийн 2 дэх хэсэг:

"2. Гадаадын иргэн олон улсын нислэгээр Монгол Улсын нутгаар 24 цагийн дотор визгүйгээр дамжин өнгөрч болно.

8/19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3/тааламжгүй этгээд гэж зарлагасан буюу Монгол Улсаас албадан гаргагдсан бол;"

9/22 дугаар зүйлийн 2,3,4 дэх хэсэг

"2. Монгол Улсад хувийн хэргээр 90 хүртэл хоногийн хугацаагаар байгаа гадаадын иргэнийг түр оршин суугч гэнэ.

3. Монгол Улсад Засгийн газар хоорондын гэрээгээр суралцах, ажил, албан тушаал эрхлэх, гадаадын төрийн бус болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн удирдах бүрэлдэхүүнд ажиллах болон гэдэнтэй адилтгах албан тушаал эрхлэн 90 хоногоос дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэнийг албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч гэнэ.

4. Хувийн хэргээр Монгол Улсад амьдрахаар 5 жилээс дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг цагаач гэнэ."

10/23 дугаар зүйл:

"23 дугаар зүйл. Оршин суух хугацаа сунгах

1. Монгол Улсад албан болон хувийн хэргээр зорчигч, түр оршин суугч, албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч гадаадын иргэний оршин суух хугацаагаа сунгуулах тухай хүсэлтийг уг асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тусын чиглэлээр хүлээн авч, хянан үзэж, зөвшөөрөх эсэхээ үндэслэлтэйгээр тодорхойлно.

2. Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суугч, цагаач гадаадын иргэний оршин суух хугацаагаа сунгуулах тухай хүсэлтийг Зөвлөл хянан шийдвэрлэнэ."

11/24 дүгээр зүйл:

"24 дүгээр зүйл. Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суугч, цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суугч, цагаач гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын 1 хувь, үүний дотор нэг улсын иргэн 0, 33 хувь хүртэл байж болно.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суугч, цагаач гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын 0,8 хувиас доош байгаа нөхцөлд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тус улсад оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид оршин суух цагаачийн тоог улс орноор нь бүрэн

эрхийнхээ хугацаанд нэг удаа, 0,8 хувиас дээш гарсан нөхцөлд жил тутам тогтооно.”

12/25 дугаар зүйлийн 1,2,3 дахь хэсэг:

“1.Монгол Улсад байнга оршин суух, цагаачлан ирэх гадаадын иргэний хүсэлт, шаардагдах бусад баримт бичгийг Зөвлөл хянан үзээд улс орны дотоод нөхцөл байдал, эдийн засгийн чадамж, хүлээн авах байгууллагын захиралга, байнга оршин суух, цагаачлах хүний боловсрол, мэргэжлийг харгалзан цагаачлах зөвшөөрлийг 5 жилээр оршин суух зөвшөөрлийг 90 хоногоос дээш хугацаагаар тус тус олгоно.

2.Байнга оршин суугч, цагаач гадаадын иргэний оршин суух хугацааг сунгах асуудлыг хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч болон байнга оршин суугч, цагаач гадаадын иргэдийн нэг улсаас байвал зохих тоонд багтаан Зөвлөл шийдвэрлэнэ.Монгол Улсад байнга оршин суугч болон цагаачлан суугаа 55, түүнээс дээш насны гадаадын иргэний Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг тухайн гадаадын иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчмыг баримтлан Зөвлөл хугацаагүй олгож болно.

3.Монгол Улсад цагаачлан ирсэн гадаадын иргэн жилд 90 хоногоос дээш хугацаагаар тус улсын нутаг дэвсгэрт байгаагүй бол цагаачлан суух зөвшөөрлийг цуцлах эсэхийг Зөвлөл тухай бүр хянан шийдвэрлэнэ. Цагаачлан суух зөвшөөрлийг буцаан авахаар шийдвэрлэсэн бол энэ тухай цагаачлан суугаа гадаадын иргэнд мэдэгдэх бөгөөд тухайн хүн уг шийдвэрийг эс зөвшөөрвөл мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.”

13/26 дугаар зүйлийн 1,3,6 дахь хэсэг:

“1.Монгол Улсад төрийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах байгууллагын уриалаар ирсэн болон зорчигчоос бусад гадаадын иргэнийг урьж ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тэдгээрийг ирсэн өдрөөс нь хойш 10 хоногийн дотор нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд, аймагт цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.

3.Монгол Улсад албан ёсны зөвшөөрөлтэй гадаадын хоронго оруулалттай болон гадаадын компани, гадаадын төрийн бус болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт ажиллахаар ирсэн гадаадын иргэн эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн дагуу нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд, аймагт цагдаагийн байгууллагад 10 хоногийн дотор бүртгүүлнэ.

6.Монгол Улсад албан болон хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн байнга оршин суугаа газраасаа өөр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрт 7 хоногоос дээш хугацаагаар хувийн хэргээр зорчвол очсон газрынхаа цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.”

14/28 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг:

"1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аль нэгжийн оршин суугч болохыг тодорхойлсон "Монгол Улсад оршин суух үнэмлэх" илгэнэ.

2.Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн гадаадад зорчихлоо оршин суух үнэмлэхээ нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд, аймагт цагдаагийн айгууллагад хадгалуулж, бүрмөсөн явах тохиолдолд хураалгана."

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд дор дурдсан гуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр цагагүй бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө."

2/5¹ дүгээр зүйл:

"5¹ дүгээр зүйл.Хураамжийн хэмжээг тогтоох

Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тасан хураамжийн хэмжээг тухайн гадаадын иргэнийг харьяалсан тстай энэ талаар харилцан ажил байх зарчмыг баримтлан тогтоож лано."

2 дугаар зүйл. Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 9 дүгээр йлийн 1 дэх хэсгийн 5,6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн гарчиг болон зүйлийн "эзэмших" гэсний дараа "хадгалах" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн гарчигийн "ашиглах" гэснийг "эзэмших"; мөн зүйлийн "иргэнийг 15000, албан тушаалтныг 25000 төгрөгөөр" гэснийг "иргэнийг 40000, албан тушаалтныг 60000 төгрөгөөр" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж

2.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр завсан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ" гэж тогтоосон хөтөлбөрийн дагуу хийн мандал, усан мандал, чулуут мандал, шим мандлын байгалийн төлөв байдлын үзүүлэлтүүдийг хэмжин тодорхойлж дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зохих шийдэл гаргах үйл ажиллагааг;

3.1.2. "Уур амьсгалын нөөц" гэж нарны цацраг, хур тунадас, агаар, хөрсний чийг, дулаан хангамж, усны хүрэлцээ, салхи, усны эрчим зэрэг хүний амьдралын хэрэгцээг хангахад ашиглаж болох байгалийн чадавхийг;

3.1.3. "Урьдчилсан мэдээ" гэж ус цаг уур, орчны төлөв байдлыг хэдэн цаг, хоног, сар, улирлын өмнө шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан тодорхойлж гаргасан мэдээг;

3.1.4. "Урьдчилан сэргийлэх мэдээ" гэж ус цаг уурын үзэгдэл, орчны бохирдол, цацраг идэвхжилт зэрэг нь хүн ам, байгаль орчин, эдийн засагт ихээхэн хохирол учруулах хэмжээнд хүрч болзошгүй тухай урьдчилан тодорхойлж гаргасан мэдээг;

3.1.5. "Нийтийн хэрэгцээний мэдээ" гэж хүн амын өргөн хэрэгцээнд зориулан хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээн зарлаж байгаа ус цаг уур, орчны мэдээг;

3.1.6. "Тусгай хэрэгцээний мэдээ" гэж хөдөө аж ахуй, зам тээвэр, эрчим хүч, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тодорхой салбарын онцлогийг харгалзсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар гаргаж байгаа ус цаг уур, орчны мэдээг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

4 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

4.1. Засгийн газар нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. ус цаг уур, орчны мэдээлэл, уур амьсгалын нөөцийг нийгэм, эдийн засгийн хөгжилд бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг сангах;

4.1.2. ус цаг уур, орчны мэдээллийг ашиглах, байгалийн болзошгүй гамшиг, орчны ноцтой бохирдлоос сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх;

4.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

5 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

5.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг:

5.1.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаархи төрийн бодлого боловсруулж хэрэгжилтэд хяналт тавих;

5.1.2. ус цаг уур, орчны мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчид мэдээлэх улсын сүлжээг зохион байгуулан түүний хөтөлбөрийг батлах;

5.1.3. тусгай хэрэгцээний мэдээний нэр төрөл, үйлчилгээний үнэ тарифийг батлах, урьдчилан сэргийлэх мэдээ болон нийтийн хэрэгцээний мэдээг радио, телевиз, мэдээллийн бусад хэрэгслээр дамжуулах, түгээх журмыг холбогдох байгууллагатай хамтран тогтоох;

5.1.4. цаг агаарын төлөв байдал, ус цаг уурын үзэгдэлд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд хяналт тавих.

6 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

6.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/ ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг:

6.1.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сүлжээний нэгжийг байгуулах, татан буулгах, шилжүүлэх;

6.1.2. ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шуурхай үйлчлэх, байгалийн гамшиг, орчны бохирдлоос сэрэмжлүүлэх арга хэмжээ авах;

6.1.3. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдал, мэдээллийн стандартчиллыг хангах;

6.1.4. шаардлагатай тохиолдолд цаг агаарын төлөв байдал, цаг уурын үзэгдэлд нөлөөлөх ажиллагаа явуулах;

6.1.5. ус цаг уур, орчны шинжилгээний мэдээллийг цуглуулах, солилцоонд гаргахад олон улсын мэдээллийн суваг ашиглах асуудлыг зохицуулах, Дэлхийн цаг уурын байгууллагын конвенцийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх;

6.1.6. ус цаг уур, орчны төлөв байдлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;

6.1.7. ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилтын ажлыг зохицуулах.

7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны
Засаг даргын эрх, үүрэг

7.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараахь эрх, үүрэгтэй:

7.1.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаархи хууль тогтоомж, Засгийн газар, бусад эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах;

7.1.2. нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжийн тасралтгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж, үйл ажиллагааны нэгдмэл дэг журмыг мөрдүүлэх;

7.1.3. ус цаг уур, орчны мэдээллээр нутаг дэвсгэрийнхээ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшиг, орчны ноцтой бохирлоос сэргийлэх ажлыг зохион байгуулах;

7.1.4. нутаг дэвсгэртээ байгалийн гамшигийн улмаас учирсан хохирлыг тооцож, хохирлоос урьдчилан сэргийлэх журама тодогтол хийж байх, учирсан хохирлын талаар төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх;

7.1.5. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжийн албан хаагчийг мэргэжлийн унрдалагаар хангах үүрэг бүхий байгууллагатай нь зөвшилцөн томилох, чөлөөлөх.

7.2. Баг, хорооны Засаг дарга ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараахь эрх, үүрэгтэй:

7.2.1. энэ хуулийн 7.1.3-т заасан бүрэн эрхийг нутаг дэвсгэртээ сэргээжүүлэх;

7.2.2. байгалийн гамшигаас учирсан хохирлыг тооцож сум, дүүргийн Засаг даргад шуурхай мэдээлэх;

7.2.3. нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талбай, тоног төхөөрөмжийг хамгаалах арга хэмжээ авах.

8 дугаар зүйл. Тусгай хэрэгцээний мэдээллээр хангах
ажлыг иргэн, аж ахуйн нэгж,
байгууллага эрхлэх

8.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч тусгай хэрэгцээний мэдээлэл гаргах үйлчилгээ эрхэлж болно.

8.2. Зөвшөөрлийг дараахь нөхцөлд олгоно:

8.2.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээг цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэх тогтолцоог бүрдүүлсэн, эсхүл төв, орон нутгийн ус цаг уур, орчны шинжилгээний байгууллагаас хангагдахаар эрээ байгуулсан байх;

8.2.2. мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх.

8.3. Зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгуудлага энэ хуулийг зөрчсөн үйл ажиллагаа явуулсан, эсхүл хэрэглэгчээс гарсан гомдол үндэслэлтэй болох нь тогтоогдвол зөвшөөрлийг хүчингүй болгож болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ

9 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ

9.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ /шашид "улсын сүлжээ" гэх/ нь нэгдмэл арга зүй, хөтөлбөрөөр ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажил гүйцэтгэх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ус цаг уур, орчны мэдээллээр хангах үүрэг бүхий байнгын тасралтгүй ажиллагаатай өртөө, харуул, хүрээлэн, төв, лаборатори зэргээс бүрдэнэ.

9.2. Улсын сүлжээний өртөө, харуулын байршил, нягтралыг үнэн зөв мэдээ гаргах шалгуурыг хяргалзан, олон улсын жишигт нийцүүлэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтооно.

9.3. Улсын сүлжээний өртөө, харуул нь төрийн өмч байна.

9.4. Улсын сүлжээний өртөө харуулыг байгуулах, тохооромжлох, татан буулгах, багаж хэрэгслээр хангах заралыг улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр, ажиллагааны зардалыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр тус тус санхүүжүүлнэ.

9.5. Аж ахуйн тодорхой хэрэгцээ, эрдэм шинжилгээний болон бусад байгууллагын захиалгын дагуу шинжилгээний өртөө, харуул байгуулах шаардлага гарвал түүнийг байгуулах, ажиллуулах асуудлыг төрийн захиргааны байгууллага нутгийн захиргааны байгуулагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.

9.6. Улсын сүлжээний өртөө, харуулыг төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтгүйгээр татан буулгах, нүүлгэн шилжүүлэхийг хориглоно.

10 дугаар зүйл. Ус цаг уур, орчны шинжилгээ

10.1. Улсын сүлжээний өртөө, харуулуудад ус цаг уур, орчны шинжилгээг нэгдмэл арга зүй, хөтөлбөрийг баримтлан густайлан сонгож авсан талбай дээр тогтоосон хугацаанд мэргэжлийн ажилтан гүйцэтгэнэ.

10.2. Өртөө, харууд хийсэн шинжилгээний дүнг төрийн захиргааны байгууллагаас тогтоосон хяналтын хугацаанд дамжуулна.

10.3. Эрдэм шинжилгээ, сургалтын зорилгоор түр хугацаагаар жиллуулах шинжилгээний өртөө, харуулд энэ хуудийн 10.1, 10.2-г авсан нь хамаарахгүй.

10.4. Энэ хуудийн 10.1-д зааснаас бусад тохиолдолд иргэн, аж хуйн нэгж, байгууллагаар ус цаг уур, орчны шинжилгээний ажлыг эрэнгээр хийлгэж болно.

10.5. Монгол Улсын иргэний агаарын тээврийн хөлгийн баг нислэгийн үед нислэгийн замын дагуух цаг уурын байдлыг одорхойлж ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагад дамжуулна.

10.6. Агаарын хөлгөөс цаг уурын мэдээ дамжуулах журмыг өрийн захиргааны байгууллага, иргэний агаарын тээврийн асуудал рхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран тогтооно.

11 дүгээр зүйл. Шинжилгээний талбай

11.1. Ус цаг уур, орчны шинжилгээ хийхэд зориулсан талбай нь усгайлаан сонгон авч төхөөрөмжилсэн, хашаалсан буюу өөр бусад айдлаар тэмдэглэж заагласан байна.

11.2. Шинжилгээний талбайн орчноо төлөвлөх чадварыг хадгалах эрилгоор уг талбайн байршлыг суурин газрын хэтийн төлөвлөгөөнд үсгэсэн байна.

11.3. Шинжилгээний талбайгаас гаднаш 100 метрийн дотор имгадалтын бүс тогтоож, уг бүсэд хэмжээт, шинжилгээ хийхэд саад оруулахуйц барилга барих, мод тарих, зам гаргах зэрэг үйл явдлагааг хязгаарлана.

11.4. Шинжилгээний талбайд зориулалтын бус багаж төхөөрөмж, усад зүйл байрлуулахыг хориглоно.

11.5. Шинжилгээний талбайд хүрэх зам нь газар эзэмшигч, шиглагчийн мэдлийн газраар хаагдаж байвал шинжилгээний талбайд нэвтрэх асуудлыг Газрын тухай хуулиар зохицуулна.

11.6. Суурин газрын бичиг уур амьсгал, орчны шинжилгээний мэд энэ хуудийн 11.3-т заасан нь хамаарахгүй.

11.7. Шинжилгээний талбайн эзэмшлийн асуудлыг Газрын тухай улнар зохицуулна.

12 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд хэмжээний нэгдмэл байдлыг хангах

12.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд стандарт, техникийн зардлага хангасан хэмжих хэрэгсэл, шинжилгээний арга ашиглана.

12.2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд ашиглах хэмжих рэгслийн шалгалт тохируулгын ажлыг зохих журмын дагуу эрх сан мэргэжлийн байгууллага сүйцэтгэж баталгаажуулна.

12.3. Баталгаажуулаагүй хэмжих хэрэгслээр хийсэн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний дүнг албан ёсны мэдээлэлд ашиглахыг риглоно.

12.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажил, ус цаг уур, орчны мэдээлэлээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангаж байгалийн гамшгаас сэргийлэх мэдээний хангалт, ашиглалтын талаар дагаж мөрдүүлэхээр гаргасан хууль тогтоомж, журам, зааврыг биелэлтэд улсын байшаагч хяналт тавина.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Ус цаг уур, орчны мэдээлэл

13 дугаар зүйл. Ус цаг уур, орчны мэдээлэл дамжуулах

13.1. Улсын сүлжээний өртөө, харуулын мэдээг харилцаа холбооны байгууллага хяналтын хугацаанд саадгүй дамжуулна.

13.2. Улсын сүлжээний өртөө, харуулын мэдээг нэгтгэж оло улсын цаг уурын харилцаа холбооны сүлжээнд оруулах, үү сүлжээнээс Монгол Улсад шаардагдах мэдээллийг хүлээн авах; дотоодын болон олон улсын холбооны суваг ашиглана. Уг сувагаг гэлээр хөдлөл, химийн болон цөмийн осол, иргэний агаарыг тээврийн нислэгт зориулсан цаг уурын мэдээ зэрэг бусад шуурха мэдээг дамжуулж болно.

13.3. Иргэд хүн ам, байгаль орчинд ноцтой нөлөөлөх байгалийн гамшиг тохиолдсон буюу тохиолдох нөхцөл бүрдсэн тухай ус цаг уур орчны шинжилгээний аль ч байгууллагад яаралтай мэдээл үүрэгтэй. Ийнхүү мэдээлэхтэй холбогдсон зардалыг аймг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон үнэмлэхүй дагуу иргэнд нөхөн олгож болно.

13.4. Байгалийн гамшигийн тухай мэдээллийг харилцаа холбоон бүх төрлийн хэрэгслээр өмчийн ялгаа харгалзахгүйгээр эхн ээлжинд шуурхай дамжуулна.

14 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны мэдээллийн архив, сан

14.1. Ус цаг уур, орчны мэдээллийн архив нь үндэсний тө архивын салбар байна.

14.2. Ус цаг уур, орчны шинжилгээний мэдээ баримтыг архив шилжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх журмыг архивын тухай хууль тогтоомжид заасны дагуу тогтооно.

15 дугаар зүйл. Ус цаг уур, орчны мэдээлэлээр хэрэглэгчийг хангах

15.1. Урьдчилсан мэдээ, байгалийн гамшигийн тухай урьдчил сэрхийлэх мэдээг аймаг, бүс нутаг, улс орны хэмжээнд нийтийг мэдээллийн хэрэгслээр түгээнэ.

15.2. Урьдчилан сэргийлэх мэдээг радио, телевиз бол мэдээллийн бусад хэрэгслээр түүнийг хүлээн авснаас хойш

минутын дотор тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийгэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлнэ.

15.3. Тусгай хэрэглээний мэдээг тухайн хэрэглэгчийн шаардлагын дагуу уг хэрэглэгчтэй хийсэн гэрээний дагуу гаргаж өгнө.

15.4. Даатгалын байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад даатгалын төлбөр олгохдоо тухайн үеийн ус цаг уур, орчны нөхцөл байдлын тухай ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагаас гаргасан тодорхойлолтыг үндэслэн олгоно.

15.5. Зураг төслийн болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажилд зөвхөн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэргэжлийн байгууллагаас тогтоосон журмын дагуу шалгаж баталгаажуулсан мэдээллийг ашиглана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

16 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1. Шүүгч буюу улсын байцаагч ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд дор дурасан хариуцлага хүлээлгэнэ:

16.1.1. ус цаг уур, орчны шинжилгээний талбайн орчноо голорхойлох чадварыг алдагдуулж энэ хуулийн 11.3-т заасныг зөрчсөн иргэнийг 15000-25000 төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000-200000 төгрөгөөр торгож зөрчлийг арилгахад гарсан зардыг төлүүлэх;

16.1.2. улсын сүлжээний хөтөлбөрт шинжилгээг тасалдуулсан, суурамч мэдээлэл гаргасан буюу мэдээг хяналтын хугацаанд дамжуулаагүй этгээдийг 3000-5000 төгрөгөөр торгох;

16.1.3. хяналт шинжилгээний улсын сүлжээний өртөө, харуулыг гөрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр татан зуулгасан, нүүдлэн шилжүүлсэн албан тушаалтныг 20000-30000 төгрөгөөр торгож, хэвийн ажиллагааг хангахад шаардагдах зардыг төлүүлэх;

16.1.4. зохих журмын дагуу баталгаажуулаагүй багаж төхөөрөмжөөр шинжилгээ, хэмжилт хийсэн, эсхүд шинжилгээ, хэмжилт огихдоо стандарт, арга зүй, зааврыг зөрчсөн албан тушаалтныг 10000-20000 төгрөгөөр торгох;

16.1.5. эрх бүхий байгууллагаас зохих магадлагаа хийгээгүй ус цаг уур, орчны мэдээг зураг төслийн болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад ашигласан албан тушаалтныг 5000-15000 төгрөгөөр, байгууллага аж ахуйн нэгжийг 100000-150000 төгрөгөөр торгох;

16.1.6. байгалийн гамшигтай холбогдсон ус цаг уур, орчны тодорхойлолтыг буруу гаргасан албан тушаалтныг 5000-10000 төгрөгөөр торгох;

16.1.7. урьачилан сэргийлэх мэдээллийг дамжуулах, нийтэд зарлан мэдээлэх ажлыг саатуулсан, урьачилан хамгаалах боломжтой арга хэмжээ аваагүйгээс ихээхэн хохирол учирсан бол зөрчил гаргасан албан тушаалтныг 15000-20000 төгрөгөөр торгох.

16.2. Ус цаг уур, орчны шинжилгээний багаж төхөөрөмжийг эвдэлсэн, ашиглан шамшигдуулсан этгээдэд Эрүүгийн хууль, Захиргааны хариуцаагын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэж, хохирлыг нөхөн төлүүлнэ.

17 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо ерөнхий байцаагчид гаргана. Ерөнхий байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл маргааныг шүүх шийдвэрлэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

I дүгээр зүйл. Дэлхийн банктэй тохиролцсон Банк, үйлдвэрийн газрын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн тээл болон Банк, үйлдвэрийн газар, хуулийн техникийн туслалцааны тээлийн Гэрээ"-д Засгийн газрын өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай 10¹ дүгээр зүйл нэмсүгэй:

**"10¹ дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах
төрийн бус байгууллагын эрх**

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага дараахь эрхтэй:

1/ бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд мэргэжлийн хяналтын эрх бүхий байгууллагатай хамтран үзлэг, шинжилгээ явуулж дүгнэлт гаргуулах;

2/ худалдаа, ахуйн болон бусад төрлийн үйлчилгээний журам, хэрэглэгчийн эрхийг хамгаалсан хууль тогтоомжийн биелэлтийг шалгах, дүнг нийтэд мэдээлэх;

3/ хүний амь нас, эрүүл мэнд, хэрэглэгчийн эд хөрөнгө болон хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалтыг зогсоох талаар мэргэжлийн хяналтын эрх бүхий байгууллага, улсын байцаагчид хандах;

4/ бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, аюулгүй байдлыг хангах талаар төрийн байгууллага, аж ахуйн нэгжид санал, шаардлага тавих;

5/ хүний амь нас, эрүүл мэнд, хэрэглэгчийн эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй буюу чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, борлуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад харууллага хүлээлгэхээр холбогдох байгууллагад санал гаргах;

6/ хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжил заасан эрх нь зөрчигдсөн хэрэглэгчийн итгэмжлэлээр эрх ашгийг нь хамгаалж шүүхэд нэхэмжлэл гаргах;

7/ хэрэглэгчийн эрхийг хамгаалах үүрэг бүхий улсын хяналтын байгууллагын үйл ажиллагааны талаар санал, дүгнэлт гаргах".

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1981 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Женев хотноо батлагдсан Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүд ахуйн болон үйлдвэрлэлийн орчны тухай" 155 дугаар Конвенцид Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу нэгдэн орсугай.

2 дугаар зүйл. 1983 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Женев хотноо батлагдсан "Тахир дутуу иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт ба хөдөлмөр эрхлэлтийн тухай" 159 дүгээр Конвенцид Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу нэгдэн орсугай.

ДЭД ДАРГА

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Конвенцид нэгдэн орох тухай" 1997 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн Монгол Улсын хуулийн 2 дугаар зүйлийн "нэмэлт хэсгийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу Конвенцийн 1-21 дүгээр зүйлийг одоогоор хэрэгжүүлэх боломжгүй" гэснийг хассугай.

ДЭД ДАРГА

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөрУлаанбаатар
хотМОНГОЛ УЛСЫН 1998 ОНЫ ТӨВЛӨРСӨН
ТӨСВИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл Улсын төвлөрсөн төсвийн 1998 оны орлогын нийт дүн, нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

	/мянган төгрөгөөр/
1.1. Орлого-бүтэ	214950089.7
1.1.1. Албан татварын орлого	143859521.1
1.1.1.а. орлогын албан татвар	43651618.4
1.1.1.б. гаалийн албан татвар	1814114.0
1.1.1.в. худалдааны албан татвар	33431316.3
1.1.1.г. онцгой албан татвар	20908651.5
1.1.1.д. автобензин, дизелийн түвшний албан татвар	4999448.3
1.1.1.е. бусад албан татвар	2692800.0
1.1.1.ж. нийгмийн даатгалын шимтгэл	36361572.6
1.1.2. Татварын бус орлого	45990568.6
1.1.2.а. хувьшаны ногдол ашиг	11107510.8
1.1.2.б. бусад орлого	14013771.4
1.1.2.в. түрээсийн орлого	5457000.0
1.1.2.г. газрын тосны орлого	500000.0
1.1.2.д. төсөвт байгууллагын өөрийн орлого	14912286.4
1.1.3. Хөрөнгийн орлого	16000000.0
1.1.3.а. өмч хувьчлалын орлого	16000000.0
1.1.4. Гадаад тусламжийн орлого	9100000.0

2 дугаар зүйл Улсын төвлөрсөн төсвийн 1998 оны зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт, нийтийн ерөнхий үйлчилгээний зардал, батлан хамгаалах арга хэмжээний зардал, төвлөрүүлэн захирагчийн санхүүжилт, тэтгэврийн даатгалын сан болон аймгийн төсөвт өгөх татлагын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

2.1. Зарлага - бүтэ	293963978.6
2.1.1. цалингийн сан	21429960.4
2.1.2. хөрөнгө оруулалт	29610000.0
Үүнээс: -шинээр эхлэх барилга объектын төсөвт өртөг	11747000.0
Үүний дотор: -1998 онд санхүү- жүүлэх хэмжээ	8384000.0

2.1.3. нийтийн ерөнхий үйлчилгээний зардал	17442877.8
2.1.4. батлан хамгаалах арга хэмжээний зардал	18767008.0
2.1.5. Улсын Их Хурлын төсөв	1258813.4
2.1.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөв	32976.1
2.1.7. Монгол Улсын Ерөнхий сайдын төсөв	27350.1
2.1.8. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн төсөв	18812.4
2.1.9. Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв	34104.6
2.1.10. Улсын дээд шүүхийн төсөв	87289.0
2.1.11. Орон нутгийн шүүхийн төсөв	926347.5
2.1.12. Прокурорын байгууллагын төсөв	684264.0
2.1.13. Улсын аюулгүй байдлыг хангах тээврийн төсөв	1184949.0
2.1.14. тэтгэврийн давтгалын санд өгөх татаас	8561400.0
2.1.15. аймгийн төсөвт өгөх татаас	27984692.7

3 дугаар зүйл. Улсын төвлөрсөн төсвөөс аймгийн төсөвт өгөх татаасын хэмжээг дор дурасанаар зунаарилан тогтоосугай:

Архангай	2194412.6
Баян-Өлгий	1988904.6
Баянхонгор	2283827.3
Булган	966137.0
Говь-Алтай	2331709.3
Дорноговь	1781224.9
Дорнод	1559341.9
Дундговь	1262336.4
Завхан	1670965.5
Өвөрхангай	845078.7
Өмнөговь	1400094.3
Сүхбаатар	1525546.4
Увс	2057833.1
Ховд	1715064.7
Хөвсгөл	2260802.3
Хэнтий	1532341.3
Говь-сүмбэр	609072.4

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Гэмт этгээдийг шинжүүлэн өгөх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын Гэрээ"-г Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

ДЭД ДАРГА

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 12 дүгээр
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

АЖЛЫН ТАВАН ӨДӨРТЭЙ ДОЛОО ХОНОГТ ШИНЖҮҮЛЭХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Бүх аж ахуйн нэгж, байгууллагыг 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ажлын таван өдөртэй долоо хоногт шинжүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 12 дугаар
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

**ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн хуулийн 33 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн "ням" гэсний өмнө "бямба" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дахь хэсгийн "46-гаас илүүгүй" гэснийг "40-өөс илүүгүй"; 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "21 өдөр" гэснийг "14 өдөр"; мөн зүйлийн 5 дахь хэсгийн "30 өдөр" гэснийг "21 өдөр" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Хөдөлмөрийн хуулийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг "Долоо хоногийн амралтын өдөр дараалсан байна" гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх зэвцгийг үндэслэн **ТОГТООХ** нь:

Улсын Их Хурлын гишүүн Р.Сандаалхан, С.Төмөр нарын санаачлэн 1997 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хууль нэмэлт оруулах тухай хуулийн төслийн агуулга нь 1997 оны 6 дугаар сарын 5-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагдсан тул уг хуулийн төслийг ивээлд хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж хууль санаачлагчид нь буцаасугай.

ДЭД ДАРГА

Ц.ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 85

Улаанбаатар
хот

**Байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж,
гишүүнээр батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их хурлын хуралдааны дэгийн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Улсын Их Хурлын гишүүн Ү.Наринцэцэгийг Аюулгүй байдал, агаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Байгаль эрчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

ДЭД ДАРГА

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар
хот

Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Засгийн газраас 1997 оны 6 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн "Тогтоол хүчингүй болгох тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн боловсруулалтад Засгийн газар судалгаа, үндэслэл, тооцоо муутай хандсан, Улсын Их Хурлаас тогтоолоор өмнө өгсөн үүргийг биелүүлэх талаар ажиллаагүй байна гэсэн үндэслэлээр "Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 1996 оны 65 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай" тогтоолын төслийг санаачлагчид нь буцаасугай.

ДЭД ДАРГА

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 87

Улаанбаатар
хот

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1998 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл"-ийг Батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1998 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл"-ийг хавсралтын ёсоор баталсугай;

2. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1998 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл"-ийн биелэлтийн явцыг 1998

онь 7, 10 дугаар сард Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газар (М.Энхсайхан) -т даалгасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

Улсын Их Хурлын 1997 оны 87 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
1998 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Бодлогын агуулга	Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх эзэн
1	2	3	4
А.Макро эдийн засгийн тогтворжуулалт			
1.Эдийн засгийг сэргээн өөрийгөө тэтгэх чадавхийг нь нэмэг-дүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийн үндсийг тавина.	-Дотоодны нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн алдагдлыг 8.8 хувиас хэтрүүлэхгүй, урсгал төсвийн алгийг 2.3 хувиас доошгүй байлгах	1998	П.Цагаан
-1998 оны дотоодны нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 4,5 хувьд хүргэх.	-Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хоёр шатлалт тогтолцоог үргэлжлүүлж мөрдүүлэх	1998	П.Цагаан
-Инфляцийн түвшинг 20 хувиас хэтрүүлэхгүй байх.	-Макро эдийн засгийн тогтворжилтыг хангах, төсөв, мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэх, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх үндсэн дээр инфляцийн түвшинг бууруулах	1998	П.Цагаан Ж.Үнэнбат
-Гадаад валютын цэвэр нөөцийг 80.0 сая ам.	-Гадаад валютын цэвэр нөөцийг импортын барааны	1998	Ж.Үнэнбат

- долларт хүргэх. 7-8 долоо хоногийн нөөцтэй тэнцэх хэмжээнд байлгах.
- Гадаадын зээлийн үндсэн өрийн үлдэгдлийг дотоодын нийт бүтээгдэхүүн, экспортой харьцуулсан түүшингийн зохистой харьцааг үндэсний эдийн засгийн агулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд тооцоо.
- 1998 П.Цагаан
- 2.Мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэхийн хамт төгрөгийн ханшийг тогтвортой байлгах, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого явуулна.
- Төгрөгийн гадаад валюттай харьцах бодит ханшийг чөлөөтэй, тогтвортой байлгахад анхаарч, төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны нөхцөлтэй уялдуулан нэг ам. доллартай харьцах төгрөгийн ханшны уналтыг ирэх онд 1997 оны гүйцэтгэлийн 5 хувиас хэтрүүлэхгүй байх.
- 1998 Х.Үнэнба
- Төгрөгийн хөрвөх чадварыг сайжруулахын хамт дотоодын зах зээл дээр гадаад валютаар арилжаа үйлчилгээ, төлбөрийн явдлыг хязгаарлах, эмх цэгцтэй болгох.
- 1998 Х.Үнэнбат 06.
- Банк хоорондын валютын солилцооны зах зээлийг хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлэх, бэлэн валютын гүйлгээнд арилжааны банкуудаас тогтоож байгаа валютын ханшны хязгаарлалтыг устгах
- 1998 Х.Үнэнбат

хяналтын механизмыг
бий болгох.

-Инфляцийн түвшин-
гийн бууралттай уял-
дуулан банкны зээл,
хүүгийн зөөлрүүлэх
бодлогыг азуулах,
бодит зээлийн хүүг
эерэг түвшинд байл-
гах.

1998

Ж.Үнэнбат
П.Цагаан

-Мөнгөний хяналтыг
чангартгах, нөөцийн
хэмжээ, төлбөрийн
чадварын харьцааг
барьж чадахгүй бай-
гаа арилжааны бан-
куудад Монголбанк-
наас зээл олгох,
Монголбанкны үнэт
цаас худалдахыг
хориглох.

1998

Ж.Үнэнбат

-Инфляцийн түвшинтэй
харьцуулахад Монгол-
банкны үнэт цаасны
бодит хүү нь эерэг
байхын хэмт арил-
жааны банкуудад
Монголбанкаас олгох
зээлийг мөнгөний
бодлогын хүрээнд
зохицуулах

1998

Ж.Үнэнбат

3. Улсын сек-
торын үр ашгийг
дээжлүүлэх,
инфляцийн түв-
шинг бууруула-
хад төсвийн
бодлогыг чиг-
лүүлнэ.

-Төсвийн зарлагыг
хязгаарлах замаар
банкны системээс
Засгийн газрын авах
зээлийг бууруулах,
цэвэр зээлийн үл-
дэгдлийг банкны
хуульд заасан хувь
хэмжээнээс хэтрүү-
лэхгүй байх

1998

П.Цагаан
Ж.Үнэнбат

-Төсвийн орлогын
бааз суурийг тэлэх
зорилгоор нэмүү өрт-
гийн татварыг мөрд-
дүүлэх, нэмэгдэл

1998

П.Цагаан

үйлчилгээ, элдээ төлбөрөөс олсон орлогыг тухайн салбарт нь хөрөнгө оруулалтын хэлбэрээр ашиглуулж байсан хуучин журмыг өөрчилж, татварын бодлогын хүрээнд хамруулах арга хэмжээ авах

-Автотээврийн болон 1998 Г.Нямдаваа
 өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татварыг авто зам, гүүр барих, засварлах ажилд зориулж, авто замын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудлыг судлан боловсруулж, УИХ-д оруулах.

-Боловсрол, эрүүл 1998 П.Цагаан
 мэндийн салбарын санхүүжилтийн өнөөгийн тогтолцоог өөрчилж, хэрэглэгчээр нь дамжуулан санхүүжүүлэх тогтолцоонд шилжих эхний алхам хийх.

4.Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

-Бүсийн зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, эрх зүйн байдал, бүсийн зөвлөлийн ажиллагааны журмыг боловсруулж мөрдүүлэх 1998 П.Цагаан
 Аймаг,
 нийслэлийн Засаг дарга

-Бүсийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, ажлын албыг туршилтын журмаар ажиллуулж эхлэх 1998 П.Цагаан
 Аймаг,
 нийслэлийн Засаг дарга

-Говийн хүн амин суурьшилт, зах хязгаар нутгийг зохиотой эзэмших, говийн усан хангамж, түлэ, 1998 П.Цагаан
 Л.Нямсамбуу
 Г.Нямдаваа

малы тэжээлийн хангамжийн асуудлаар санал боловсруулах

Б.Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин сэргээх

- | | | | |
|---|--|------|--|
| 5.Аж үйлдвэрийн салбарын | -Түлэ, эрчим хүчний үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангаж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өсгөх. | 1998 | Г.Нямдаваа
Л.Нямсамбуу
Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 6.тээгдэхүүний бодит өсөлтийг 4-өөс доошгүй хувьар нэмэгдүүлнэ. | -Алт болон эрдэс, түүхий эдийн байлгийн олборлолтыг нэмэгдүүлэх. | 1998 | Л.Нямсамбуу
Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Газрын тосны эрэл хайгуул, өрөмдлэгийн ажлыг эрчимжүүлж, газрын тос олборлох, экспортлох ажлын бэлтгэлийг хангах. | 1998 | Л.Нямсамбуу |
| | -Боловсруулах аж үйлдвэрт бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж хөнгөн, хүнсний үйлдвэрийг сэргээх. | 1998 | Л.Нямсамбуу
Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Ховдын цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулах асуудлыг судалж, шийдвэрлэх. | 1998 | Г.Нямдаваа
Л.Нямсамбуу |
| | -Олон улсын үнэт цаасны зах зээл Дээр Монгол Улсын Засгийн газрын дунд хугацааны бондыг борлуулах асуудлыг Монголбанктай хамтран шийдвэрлэх, түүнээс орох орлогыг уул уурхай, хөдөө аж ахуй болон тэргүүлэх салбарын | 1998 | П.Цагаан
Ж.Үнэнбат
Үнэт цаасны хороо |

- хөрөнгө оруулалтын эх үүсвэрт ашиглах
- Аж үйлдвэрийн тухай хуулийг боловсруулж, батлуулан мөрдүүлэх 1998 Л.Нямсамбуу
Г.Нямдаваа
- Хоршооллыг хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх 1998 Л.Нямсамбуу
- Хонь, тэмээн сүрэг хорогдон нийт мал сүрэгт эзлэх хувийн жин буурч байгаад судалгаа, дүгнэлт гаргаж, мал сүргийн зохистой бүтэц бүрдүүлэхэд чиглэсэн эдийн засгийн механизмг боловсруулж шийдвэрлэх, малмн тоо толгойг өсгөх. 1998 Л.Нямсамбуу
Аймаг, нийслэлийн Засаг дарга
- Бэлчээрийн даацмг шинэчлэн тогтоох, судалгаа явуулах. 1998 Л.Нямсамбуу
- Бэлчээр ашиглалтыг сайжруулах зорилгоор ажиллахгүй байгаа инженерийн хийцтэй худгуудыг сэргээн засварлах арга хэмжээ авах. 1998 Л.Нямсамбуу
- Хүнсний хангамж, чанарын баталгааг сайжруулах, дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих, зах зээлийг хамгаалах үүднээс импортын барааны гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг уян хатан хянан үзэх. 1998 Л.Нямсамбуу
- Эх орно үйлдвэрийн болон импортын 1998 Л.Нямсамбуу

бараа, материал, орсон нутгийн түүхийг эдийн бөөний худалдламы тогтолцоог зах зээлийн зарчимд тулгуурлан бүрдүүлэх зхлэлийг тавих.

- | | | | |
|--|---|-------------|--|
| <p>6.Газар тариалангийн салбарыг бүтцийн өөрчлөлт хийх, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үндсэн дээр 1998 онд үр тарианы үйлдвэрлэлийг сэргээх.</p> | <p>-Газар тариалангийн салбарыг сэргээн хөгжүүлэх арга хэмжээг иж бүрнээр нь авч үзэн, энэ асуудлаар Үэсгийн газрын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.</p> | <p>1998</p> | <p>П.Нямсамбуу</p> |
| | <p>-Газар тариалангийн үйлдвэрлэлийг байгалийн болон зах зээлийн өрсөлдөөс хамгаалах боллого, арга хэмжээг шээ дараатай авч хэрэгжүүлэх.</p> | <p>1998</p> | <p>П.Нямсамбуу</p> |
| | <p>-Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийг шинэчлэх арга хэмжээ авах.</p> | <p>1998</p> | <p>П.Нямсамбуу</p> |
| | <p>-Төрийн өмчийн оролцоотой газар тариалангийн эв ахуйн нэгжүүдийн төрийн өмчид ноглох хэсгийг хувиарлах дуусгах.</p> | <p>1998</p> | <p>П.Нямсамбуу</p> |
| | <p>-Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг иж бүрнээр нь авч үзэх хэрэгжүүлэх.</p> | <p>1998</p> | <p>П.Нямсамбуу
Аймаг, нийслэлийн Засаг дарга</p> |
| | <p>-Трийн болон улаан буудайн улсын нөөцийг нэмэгдүүлэх.</p> | <p>1998</p> | <p>П.Нямсамбуу</p> |

Бордоом улсын нөөц
шинээр бүрдүүлэх

В. Улсын хэвшлийн хүрээг багасгах

<p>7. Хувийн хэв-шилд тулгуурласан эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх стратегийн бодлогын хүрээнд улсын хэвшлийн цар хүрээг багасгах, төсвийн зарлагыг хязгаарлах, төрийн өмчийг хувиулах ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авна.</p>	<p>- Үндэсний татварын тогтолцоог нүүлж, төсвийн хөндлөнгийн хяналтыг нэвтрүүлэх.</p>	1998	П.Цагаан
	<p>- Төрийн захиргаа удирдлагын бүтцийг өөрчлөн шинэчилж, төрийн захиргааны төсвийн зарлагын хяналтын тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх механизмыг бий болгох, энэ чиглэлээр туршилтын төслийг нэг яам, 3 агентлагт хэрэгжүүлэх.</p>	1998	П.Цагаан
	<p>- Боловсрол олгох чадавхийг сайжруулах чиглэлээр сургалтын агуулганд тохирсон бүтцийг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.</p>	1998	Ч.Пхагва-жан
	<p>- Үндэсний үйлдвэрлэлийн чадавхийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн өмчийн ашиглалтын үр ашгийг сайжруулах зорилгоор төрийн</p>	1998	П.Цагаан П.Нямсам-буу Г.Нямцэва

өмчийг хувиулах
ажлыг эрчимжүүлэх
замар 16.0-аас
доошгүй тэрбум төг-
рөгийг төсөвт төвлө-
рүүлэх.

-Өмч хувиулалыг 1998 П.Цагаан
эрчимтэй, ил тод,
нээлттэй хэрэгжүү-
лэхийн хамт өмч-
лөлийг хэт тархай
байрлаас төвлөрүүлэх
зарчим баримтлах.

-Төрийн өмчийг 1998 П.Цагаан
хувиулахдаа нийтийн
болон битүүмжилсэн
дуудлага худалдааны
аргыг өргөн хэрэг-
лэх, гадаадны хөрөн-
гө оруулагчдыг татан
оруулах, ил тод
явуулах.

8. Үнэт цаасны зах зээлийг либеральчлан хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, хөрөнгийн зах зээлийг зохицуулах хууль тогтоомжийг боловсронгуй болгож, үнэт цаасны зах зээлд тавих хяналтыг сайжруулна.

-Үнэт цаас гаргах замар хийх хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үнэт цаасны зах зээлд оролцох гадаадны хөрөнгө оруулагчдын сонирхлыг идэвхжүүлэх нөхцөлийг судалж бий болгох.

-Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг төлөмжүүлэх, хөрөнгө оруулалтын санг үүсгэж үйл ажиллагаагаа явуулах эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлэх.

- Үнэт цаасны арилжааны мэдээллийн сүлжээг сайжруулж хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хувьцааг чөлөөтэй арилжих нөхцөлийг бүрдүүлэх. 1998 П.Цагаан
Үнэт цаасны хороо
- Үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж мөрдүүлэх. 1998. 06. П.Цагаан
Үнэт цаасны хороо
- Үнэт цаасны үнэ, ханшид хууль бусаар нөлөөлөх аливаа оролдлогыг хянах тогтолцоог бий болгон хэрэглэх. 1998. 06. П.Цагаан
Үнэт цаасны хороо
- Хөрөнгийн биржид бүртгэгдэж баталгаажсан хөрөнгө оруулалтын эрхийн бичгийг хувьчлагдах хөрөнгөөр баталгаажуулах ажлыг шийдвэрлэх дуусгах. 1998 П.Цагаан
Үнэт цаасны хороо,
Төрийн эмчийн хороо
- Хөрөнгийн биржийг хувьчлах төсөл боловсруулж хэрэгжүүлэх. 1998 П.Цагаан
9. Улсын хэвдлийн хүрээг багасгахын хамт, түүн дэх төрийн оролцоог бууруулна. -Нийслэлийн нийтийн зорчигч тээврээс бусад аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг төрийн эмчийн байгууллагад тойруу замаар төсвөөс элдэв төрлийн тэтгэлэг, хөнгөлөлт, төсвийн зээл олгодог дүрэм, журмыг ханан үзэх, зогсоох. 1998 П.Цагаан
П.Нямсам-буу
Г.Нямдаваа
- Өмнө нь Банкны байгууллагаас их хэмжээний зээл аваад төлөөгүй байгаа улсын үйлдвэр, аж ахуйн газруудын төл- 1998 П.Цагаан
П.Нямсам-буу
Г.Нямдаваа

бөрийг барагдуулах, дахин их хэмжээний зээлийн өрд барагдахаас сэргийлэн эдгээр ах ахуйн газруудад бүтцийн өөрчлөлт хийж зах зээлийн бэрмжлэлтэй болгох.

-Улсын үйлдвэрийн газруудад олгож байгаа төсвийн зээлийг хязгаарлахын хамт төсвийн зээлийн хүүг зах зээлийн түвшинд хүргэх, зээлийг эргүүлэн төлөх төлбөрийн хармуцлагыг чангатгах.

1998

П.Цагаан
П.Нямсан-
буу
Г.Нямдаваа

-Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Төв аймгийн Дэлгэрхаан сумдад цахилгаан дамжуулах шугам барих бэлтгэл хангахад орон нутгийн байгууллага, иргэдийн үүсгэл санаачлагыг дэмжиж өрнүүлэх ажлыг зохион байгуулах.

1998

Холбогдох
аймгийн
Засаг
дарга

Г.Хувийн хэвшлийг дэмжих

10.Арилжааны банкуудын санхүү, төлбөрийн чадварыг сайжруулахад чиглэсэн бүтцийн өөрчлөлтийг олон улсын санхүүгийн бай-

-Банкны тухай хууль тогтоомж, Монгол-банкнаас тогтоосон дүрэн, журмыг арилжааны банкууд хэрхэн мөрдөж байгаад таних хөндлөнгийн хяналт (аудит)-ыг өргөжүүлэх.

1998

Ж.Үнэнбат
П.Цагаан

гууллагатай
хамтран хэрэг-
жүүлж банк,
санхүүгийн
эрүүл тогтол-
цоог бүрдүүлэх
замаар бизне-
сийн таатай
орчинг бий
болгоно.

- Банкнаас зээл аваад 1998. Ж.Үнэнбат
төлөөгүй зээлдэгч- 01. П.Цагаан
дийг бүртгэх, олон
түмэнд мэдээлж байх
зээлийн мэдээллийн
товчоог байгуулж
ажиллуулах.
- Иргэд, аж ахуйн 1998. Ж.Үнэнбат
нэгж, байгууллагын 06. П.Цагаан
мөнгөн гүйлгээг саа-
туулдаг арилжааны
банкуудад хүлээлгэх
хариуцлагыг чангат-
гах, түүнийг хянах
хяналтын тогтолцоо,
механизмыг боловс-
ронгүй болгох.
- Хадгаламжийн банк, 1998 Ж.Үнэнбат
Сэргээн босголтны П.Цагаан
банкны төлбөрийн
чадвар, удирдлагын
чадавхийг дээшлүү-
лэх, төлбөрийн чад-
вар нь суларсан
ХОТБ-ийн банк, ХАА-н
банкны зээлийн үнэл-
гээ, өр барагдуулах
ажлыг сайжруулах.
- Төрийн өмчийн орол- 1998 П.Цагаан
цоотой банкуудын Ж.Үнэнбат
төрийн өмчид ногдох
хэсгийг хувьчлах, уг
хувьчлалд гадаадны
нэр хүнд бүхий сан-
хүүгийн байгуулла-
гуудыг татан орол-

цуулах ажлыг зохион
байгуулах.

- Банк, санхүүгийн 1998 Ж.Үнэнбат
эрүүл орчинг бүр-
дүүлэхэд банкны
хяналт шалгалтыг
сайжруулах явдал
чухал үүрэгтэй гэж
үзэн Арилжааны бан-
куудын актингийн хос-
лол буюу зээлийн
багцны чанарт байн-
гын үнэлэлт өгөх,
зээлийн болзоогүй
алдагдлын санг
шаардлагын хэмжээнд
байгуулах, зээлийг
алдагдал болгох яв-
дал үнэн зөв хийгдэж
байгаа эсэхийг хянах
арга зүй, журмыг
боловсруулж мөр-
дүүлэх. 1998 П.Цагаан
Х.Үнэнбат
- Зээлийн баталгаа
болон барьцааны
харилцааг зохицуул-
сан хууль боловс-
руулж, батлуулан
мөрдүүлэх. 1998 П.Цагаан
Л.Нямсам-
буу
Г.Нямдаваа
- 11.Бизнес хөг-
жих таатай
өхцөлийг бүр-
түүлэх, хөрөн-
гө оруулалтыг
сэхүүлэн дэм-
жих замаар
идийн засгийн
сөлтийг хан-
гаж хөрөнгө
оруулалтын үр
шгийг дээш-
лүүлэх.
- Хөрөнгө оруулалтын
нийт эх үүсвэрийг
дотоодын нийт бү-
тээгдэхүүний 24.0
хувианд хүргэх.

- Цахилгаан эрчим хүч, 1998 Л.Нямсамбуу
зам тээвэр, холбоо, Г.Нямдаваа
усан хангамжийн шугам
сүлжээг хөгжүүлэх үнд-
сэн дээр аж үйлдвэрийн
парк байгуулах асууд-
лыг судалж, хэрэгжүү-
лэх үндсийг тавих.
- Тулга, эрчим хүч, уур 1998 Г.Нямдаваа
усны хэмнэлтийн бод-
лого боловсруулж
хэрэгжүүлэх, алдагдлыг
бууруулах арга хэмжээ
авах.
- Интернетийн шинэ тех- 1998 Г.Нямдаваа
нологи GSI системийг
нэвтрүүлэх арга хэмжээ
авах.
- Гадаадны зээл туслам- 1998. П.Цагаан
жийг зохицуулах хууль 09 Л.Нямсамбуу
зүйн үндсийг бий Г.Нямдаваа
болгож мөрдүүлэхийн
хамт, зээл, тусламжийн
удирдлага, зохицуу-
лалт, хяналтыг цэгцтэй
болгох арга хэмжээ
авах.
- Гадаадны хөрөнгө 1998 Л.Нямсамбуу
оруулагчдад "нэг дор
үйлчлэх алба" байгуулж
ажиллуулах.
- Бичлэх ухаан, тех- 1998 Ч.Лхагважав
никийн үр дүнг үйлд-
вэрлэл, амьдралд
нэвтрүүлэх, борлуулах
ажлыг эрчимжүүлэх
зорилгоор эрдэм шин-
жилгээний ажлын гүй-
цэтгэгч, захиалагчийн
эрх, үүрэг, хариуц-
лагыг дээшлүүлэх эрх
зүйн нөхцөлийг бүрдүү-
лэх.
- Бизнесийг хөгжүүлэх 1998 П.Цагаан
зорилгоор үндэсний Л.Нямсамбуу

хөрөнгө оруулагчдад гадаадийн хөрөнгө оруулагчдаас дутахааргүй таатай нөхцөл олгоход чиглэсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийг боловсруулж батлуулан мөрдүүлэх.

12.Хувийн салбарыг хөгжүүлэх үндсийн нэг нь эдийн засгийг нээлттэй, худалдааг чөлөөтэй болгох явдал гэж үзнэ.	-Эдийн засгийн гадаад харилцааны хүрээг тэлэхэд чиглэсэн бодлого явуулах, ялангуяа Зүүн өмнөд Азийн орнуудтай хийх худалдааг ирэх онд өргөжүүлэх.	1998	Ш.Алтангэрэл
	-Дэлхийн худалдааны байгууллагад элссэнтэй холбогдуулан гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийн дагуу холбогдох хууль тогтоомж, хуримд өөрчлөлт оруулах ажлыг түргэтгэж, гадаад худалдааг олон улсын жингт нийцүүлэн чөлөөтэй болгох ажлыг туунтай явуулах.	1998	Ш.Алтангэрэл

Д.Хүний нөөцийн хөгжил, нийгмийн хамгаалал

13.Макро эдийн засаг тогтворжиж эдийн засаг, үйлдвэрлэл сэргэхийн хэрээр түүний бодит боломжид тулгуурлан хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах	-Нийгмийн цаатгалын тогтолцоог зах зээлийн харилцаанд зохицуулан өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хурлын 1998 оны хэврийн чуулганд хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх.	1998. II улирал	Н.Зориг
---	---	-----------------	---------

зорилтыг
шийдвэрлэнэ.

-Нийгмийн халамжийн үйлчилгээний зохистой орчин үеийн шаардлага, эрэлтийг хангахуйцаар өргөтгөн өөрчлөх, санхүүжүүлэлтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх, нийгмийн халамжийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Нийгмийн халамжийн багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хурлын 1998 оны хаврин чуулганд хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх.

1998. И.Зориг
I-II
улирал

-Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг тогтворжуулах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгож, хүрээг өргөтгөх чиглэлээр одоогийн мөрдөж байгаа хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хурлын 1998 оны хаврин чуулганд хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх.

1998. И.Зориг
I-II
улирал

-Ажилгүйдлийн даатгалын сангийн үндэсгийг зохистой зарцуулах, хөдөлмөр зохицуулалтын албаны ажлыг сайжруулах, ажлын байр бий болгох, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагааны өгөөжийг дээшлүүлэх үүднээс эдийн

1998. И.Зориг
I-II
улирал

засгийн өсөлт бий болгоход шууд нөлөөлөх олон төрлийн ажил, мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэгдсэн богино хугацааны ули хатан сургалт явуулах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

-Тахир дутуу иргэдийн талаар төрөөс баримтлах бодлогын төсөл боловсруулж, Удсын Их Хурлын 1998 оны хаврын чуулганд хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх.

1998. I-II улирал

Л.Зориг

-Бидэр насны тэтгэврийн ялгаатай тогтоосон зөрүүг аригаж, инфляцийн түвшинтэй уялдуулан тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх.

1998

Л.Зориг
Ц.Цагаан

-Төрийн албаны ажилтны цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх.

1998

Ц.Цагаан
Л.Зориг

-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоож мөрдүүлэх, үүнээс үндэслэн цалин хөлсний хийгийг өөрчлөх.

1998

Л.Зориг

-Амьжиргаагаа дээдлүүлэн орлого, цалин хөлсөө нэмэгдүүлэхийн төлөө хөдөлмөрлөх байгаа иргэдийг бүх талаар дэмжих зорилгоор ажил олгогч, ажилтны хооронд байгуулах хөдөлмөрийн болон хамтын гэрээний үүргийг нэмэгдүүлэх.

1998

Л.Зориг

- Хүн ам зүйн ачаалал, 1998 П.Зориг
 нөхөн үржихүйн нөөц,
 суурьших хэрэгцээг
 харгалзан хүн амын
 нутагилмын зохистой
 бүтцийг бүрдүүлэх,
 шилжих хөдөлгөөнийг
 зохицуулах эрх зүйн
 үндсийг боловсруулж
 мөрдүүлэх.
- Ахмад настан, эмэг- 1998 П. Зориг
 тэйчүүд, хүүхэд,
 залуучууд, тахир дутуу
 иргэдийн нийгмийн хам-
 гааллын асуудлыг шийд-
 вэрлэхэд тэдний эрх
 ашгийг хамгаалдаг
 төрийн бус байгуул-
 лагуудыг оролцоог
 нэмэгдүүлж, төрийн
 байгууллагын зарим
 үүргийг гэрээний дагуу
 тэднээр гүйцэтгүүлэх.
- Хирэнсний болок хүү- 1998 П.Зориг
 хэд төрүүлсний дараа
 олгох тэтгэмжийг
 нэмэгдүүлэх талаар
 санал боловсруулж
 шийдвэрлүүлэх.
- Еинээр ажлын байр 1998 П.Зориг
 нэмэгдүүлэх замаар хүн
 амын хөдөлмөр эрхлэл-
 тийн түвшинг дээш-
 лүүлж, ажилгүйдлийн
 түвшинг эдийн засгийн
 идэвхтэй хүн амын 6,5
 хувиас хэтрүүлэхгүй
 байх, аймаг, нийслэл,
 сум, дүүрэг бүр
 ажилгүйдлийн түвшингээ
 тодорхойлон түүнийг
 бууруулах арга хэмжээг
 хэрэгжүүлэх.
- Хөдөлмөрийн багтаамж 1998 П.Зориг
 ихтэй, нийтийг хамар-
 сан ажилд (зам талбай
 барих, суваг шуудуу
 сум,

ухах гэх мэт) ажлагүй иргэдийг татан оролцуулах замаар тэдний хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх.		дүүргийн Засаг дар
-Тахир дутуу хүнд зориулан ажлын байр бий болгохыг дэмжиж, хөдөлмөр эрхлэх боломжийг нь эрх зүйн баталгаатай болгох.	1998	П.Зориг
-Тахир дутуу иргэний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор тахир дутуу иргэний зорчих, биеэ авч явахад нь зориулж хүн ам орноор зорчиж, цуглардаг үйлчилгээ, үзвэрийн газар, талбай, зам гүүр болон утсан харилцааны хэрэгсэл бий болгох талаар тодорхой алхам хийх.	1998	П.Зориг
-Нийгэмийн эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх тусламжийн агуулгыг боловсронгуй болгох, жинхэнэ эзэнд нь хүргэх сударга механизм хэвшүүлэх зорилгоор нийгмийн халамжийн тогтолцоог сайжруулах арга хэмжээ авах.	1998	П.Зориг
-Хөдөлмөр хамгаалал, авуулгүй ажиллагааны үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.	1998	П.Зориг
-Хөдөлмөрийн асуудлаар улсын хэмжээний бага	1998	П.Зориг

хурлыг зохион байгуулах.

- | | | |
|--|------|--|
| <p>-Бүтцийн өөрчлөлтөд хамрагдах боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээний болон төрийн захиргааны байгууллага, үйлдвэрийн газрын ажлаас чөлөөлөгдсөн хүмүүсийг мэргэжлийн түр сургалтад хамруулахын зэрэгцээ тэтгэмжийг зохих журмын дагуу олгох.</p> | 1998 | <p>П.Зориг
Ч.Лхагважав
П.Цагаан</p> |
| <p>-Сургуулийн өмнөх боловсролыг бэхжүүлэх төсөл, мэргэжилтэй ажилчин бэлтгэх тогтолцоог шинэчлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж эхлэх.</p> | 1998 | <p>Ч.Лхагважав
П.Зориг</p> |
| <p>-Боловсролын салбарин чанар үр ашгийг дээшлүүлэх, бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэх, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох.</p> | 1998 | Ч.Лхагважав |
| <p>-Боловсролын салбарт багш, суралцагч, эцэг эхийн төлөөлөл, сонирхлын бүлгийн оролцоог нэмэгдүүлсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх.</p> | 1998 | Ч.Лхагважав |
| <p>-Их, дээд сургууль, коллежид шинээр элсэгчдийн 60-аас доошгүй хувийг сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр сургах, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд элсэгчдийг сургалтын төлбөрөөс чөлөөлөх,</p> | 1998 | <p>Ч.Лхагважав
Аймаг,
нийслэлийн
Засаг дарга</p> |

ерөнхий боловсролын сургуулийн 8 дугаар анги төгсөгчдийн 70-аас доошгүй хувийг 9 дүгээр ангид элсүүлэх.

-Боловсролын доод түвшинг төрөөс шалгах төстийн тогтолцоог бүрдүүлж, магадлан итгэмжлэх байгууллагыг байгуулж, мэргэжлийн сургуулиудад анхны магадлан шинжилгээ явуулах. 1998 Ч.Лхагважав

-Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын мэргэжил дээшлүүлэх болон сургалтын хөрөнгийг төвлөрүүлж, зохион байгуулах ажлыг бүсчилэн хэрэгжүүлэх. 1998 Ч.Лхагважав

-Соёлын салбарын менежмент, менежерийн үйл ажиллагааг арилжааны чиглэлээр хөгжүүлж, соёл, урлагийн үйлчилгээг өргөтгөх. 1998 Ч.Лхагважав

-Эгийн голын усан цахилгаан станцын барилга, усан сангийн талбайд илэрсэн түүх соёлын дурсгалт зүйлийг авран хамгаалж шинжлэн судлах. 1998 Ч.Лхагважав

-Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, "Судалгаа-туршилт-үйлдвэрлэл-бизнес"-ийн орчин бүрдүүлэх талаар эрх зүйн баримт бичиг, Шинжлэх ухаан, технологийн тухай, Технологи дамжуулах тухай, Эрдэм шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих 1998 Ч.Лхагважав

тухай хуулиудын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

-Енэ зүйл бүтээх, туурвих ажлыг хөхүүлэн дэмжих, урамшуулах механизм, оюун бүтээлийг үнэлэх шалгуур бий болгож холбогдох журам, зааврыг гаргах мөрдүүлэх. 1998 Ж.Амарсанаа
Ч.Лхагважав

-Эм хангамжийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийж дуусган, эмийн үйлдвэрлэл, импорт, худалдаанд тавих чанарын хяналтыг эрс сайжруулах. 1998 Л.Зориг

-Эмнэлгийн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт боловсруулж, улсын чанартай томоохон эмнэлгүүдийг оношлогоо, эмчилгээний техник хэрэгслээр хангахад төрөөс хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх. 1998 Л.Зориг
П.Цагаан

-Хүнсний ахуйгүй байдлыг хангахтай холбогдсон хяналтыг чангатгах, чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй байх механизмыг бүрдүүлэх. 1998 Л.Зориг

-Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нийгмийн эмзэг давхарга болон бага насны хүүхдийн хоол тэжээлийн хангамж, бодит 1998 Л.Зориг

хооллолтын байдалд судалгаа хийж, өрхийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг идэвхжүүлэх.

-Малжуулах төслийг өргөжүүлэх замаар ядуу иргэдийг малжуулах үйл ажиллагааг эрчимтэй явуулах. 1998 Аймаг, сумын Засаг дарга

-Мал бүхий иргэдийн орлогын албан татваргаар хуримтлагдах хөрөнгөөр иргэдийг малжуулах боллого явуулах. 1998 Аймаг, сумын Засаг дарга

-Спортыг клубын хэлбэрээр хөгжүүлэх чиглэл баримтлан спортын уралдаан тэмцээнд оролцох гаргасан амжилт, үр дүнгээр нь тамирчин дасгалжуулагчдыг урамжуулах болон санхүүжүүлэх механизмийг нэвтрүүлэх. 1998 Л.Зориг

-Бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд сондон анхаарч, хүн амын бие балдарын чийрэгжилтийн түвшингийн үнэлгээг тогтоож, нийтийн биеийн тамирын хөдөлгөөнд бүх нийтийг оролцуулах зорилгоор Үндэсний спортын анхдугаар спартакиадыг зохион явуулах. 1998 Л.Зориг Аймаг, нийслэлийн Засаг дарга

-Олон нийтийн үүсгэл санаачлагаар эхлүүлсэн Бөхийн өргөөний нуусаагүй барилгыг төслийн хөрөнгө болон эргэн төлөгдөх зээлийн хөрөнгөөр санхүүжилт 1998 Л.Зориг Н.Цагаан

хний барьж дуусгах.

- | | | | |
|---|---|------|---------------------------|
| 14. Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглахын зэрэгцээ байгаль хамгаалах үндсийг бэхжүүлэн эдийн засаг, технологи, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ. | -Төрөөс экологийн талаар баримтлах бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлж эхлэх, Байгаль орчин болон эдийн засгийн харилцааны хууль тогтоомжийн уялдааг хангах. | 1998 | Ц.Адъяа-сүрэн |
| | -Уул уурхайн салбарт байгаль орчинг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах талаар тавих хяналтыг чангатгах, ашиглагдсан талбай болон орчин доройтлыг нөхөн сэргээх арга хэмжээ алах. | 1998 | Ц.Адъяа-сүрэн
Л.Нямсам |
| | -Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, орчин бохирдлыг бууруулах технологи, стандарт, зөвшөөрлийн тогтолцоог боловсруулж бонгох. | 1998 | Ц.Адъяа-сүрэн |
| | -Байгаль орчинтой зохицсон цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх үзэл баримтлалыг боловсруулах. | 1998 | Ц.Адъяа-сүрэн |
| | -Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | 1998 | Ц.Адъяа-сүрэн |
| | -Байгаль орчин стратегийн удирдлага, олон нийтийн хяналт, нэгдэлний тогтолцоог сайжруулах. | 1998 | Ц.Адъяа-сүрэн |

	-Нийслэлийн хогийн цэгүүдийг дарх зориулалтын газарт төвлөрүүлэн нийлүүлэх арга хэмжээ авах.	1998	Ц.Адьяа-сүрэн Нийслэлийн Засаг дарга
15.Цэргийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, улс орноо батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, зэвсэгт хүчнийг мэргэжлийн цэргийн чиг хандлагатай болгон өөрчлөх, хилийн цэргийг бэхжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	-Батлан хамгаалах гадаад улс төрийн бодлогод улс төр-дипломатын аргыг эн тэргүүнд тавьж, хоёр хөрш болон дэлхийн нөлөө бүхий бусад оронтой цэргийн салбарын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.	1998	Д.Дорлигжав
	-Зэвсэгт хүчнийг шинэ бүтэц, зохион байгуулалтад шилжүүлэх ажлыг үндсэнд нь дуусгаж бэхжүүлэх.	1998	Д.Дорлигжав
	-Хилийн харуул манааг холбоожуулах, таллах хэрэгсэл, хувцас, хүнсний хангамжийг сайжруулах арга хэмжээ авах.	1998	Д.Дорлигжав
	-Иргэний болон цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоо, хөтөлбөрийг шинэчлэх.	1998	Д.Дорлигжав
	-Цэргийн дүйцүүлэх албаны үйл ажиллагааг эхлүүлэх	1998	Д.Дорлигжав
16.Эрх зүйн нийцтгэлийг гүнзгийрүүлнэ.	-Эрх зүйн нийцтгэлийн хөтөлбөрийг оноогийн шаардлагад нийцүүлэн боловсруулж	1998	Ж.Амарсанаа

хэрэгжүүлэх.

-Иргэний хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг шинэчлэх.

1998

Ж.Амарсанаа

-Захиргааны вүүх байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх.

1998

Ж.Амарсанаа

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар
хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар
1998 онд баримтлах үндсэн зорилт,
хэрэгжүүлэх арга хэмжээний
төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Гадаад худалдааны нөхцөл болон төлбөрийн тэнцлийн урсгал тооцоог өмнөх жилээс өөрчлөгдөхгүйгээр тооцсон төгрөгийн америк доллараар илэрхийлэгдэх ханшийн хэлбэлзэлтийн хязгаарыг 5 хувиар тогтоож 1998 оны мөнгөний бодлогын үндсэн зорилт болгон мөрдсүгэй.

2. Төрөөс мөнгөний бодлогын талаар 1998 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

3 Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газартай хамтран зохион байгуулж, дүнг улирал бүр Улсын Их Хуралд танилцуулах байхыг Монголбанк /Ж.Үнэнбат/-д даалгасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР
1998 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Энэхүү төлөвлөгөө нь 1998 оны мөнгөний бодлогын үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэхийн тэрэгцээ Засгийн газар, Монголбанкнаас олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран явуулж байгаа хөтөлбөрийн монго, санхүүгийн тогтоосон үзүүлэлтийг хангах, бодлогын ба техникийн шинж чанартай арга хэмжээг хэрэгжүүлэхтэй уялдана.

Мөнгөний бодлогын талаар

1. Мөнгөний бодлогын хэрэгслүүдийг ашиглахдаа банкны тухай хууль тогтоомжийн шаардлагад бүрэн нийцүүлнэ.

2. Банкны заавал байлгах нөөцийг хангуулж илүүдэл нөөцөө чөлөөтэй байршуулах санхүүгийн хэрэгсэл, нөхцөлийг бүрдүүлнэ.

3. Банканд шинээр олгох тээлийн барьцаа, баталгааг бүрэн хангуулна.

4. Засгийн газарт олгосон тээлийг хуулиар тогтоосон хэмжээнд хүртэл бууруулах дэс даралтай арга хэмжээ авна.

5. Монголбанкнаас компани, байгууллагад олгосон тээл, гаргасан баталгаа, эх үүсвэргүйгээр гүйцэтгэсэн талаад төлбөрийн явлагыг барьцдуулах ажиллагааг эрчимжүүлэн гэрээ хэлцлийг нөхөж байгуулах, төлбөрийн хуваарийг тогтоох, өрийг худалдах, үйл ажиллагааны хяналтыг тогтоож, бүтцийг өөрчлөх замар явлагыг бууруулах арга хэмжээ авна.

6. Төв банкны үнэт цаасны хүүг инфляцийн өнгөрсөн болон хүлээгдэж байгаа түвшнөгээс дээгүүр тогтоож мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүүг тогтоох суурь үзүүлэлт болгон ашиглана.

7. Заавал байлгах нөөц, банкны үйл ажиллагааны зохистой харьцааны холбогдох шалгуур үзүүлэлт зөрчсөн банкны тээлийн үлдэгдэлд хязгаарлалт тогтоож мөрдүүлнэ.

8. Банк хоорондын итгэлцэл, мөнгөний захын үйл ажиллагааг сэргээж, нөөц мөнгөний удирдлагад шилжих үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Банкны бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх талаар

9. Банкуудын төлбөрийн чөлөөт өөрийн хөрөнгийг тогтоосон хэмжээнд хүртэл нэмэгдүүлдэхэд чиглэсэн бүтцийн өөрчлөлтийг хуульд зассан хэлбэрүүдээр үргэлжлүүлэн ийгнэ.

10. Монголбанкны хяналт шалгалтын газрын нөөц бололцоо, чадвар, шалгалтын давтамж, түүний мөрөөр авах арга хэмжээ, үр өгөөжийг дээшлүүлнэ.

11. Банкны зээлийн эрсдлийг бууруулах, зээлийн багийн чанарыг сайжруулахад чиглэсэн зээлдүүлэх, зээл авах эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээг төрийн холбогдох шатны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

12. Банк хоорондын зээлийн мэдээллийн сангийн хэрэглээний хүрээг өргөжүүлж, улмаар татвар, хууль хяналтын байгууллагын мэдээллийн сүлжээтэй холбох арга хэмжээ авна.

13. Банкны үйлчилгээг орон нутагт сайжруулах, төлбөр тооцоог түргэтгэх, банкны бус санхүүгийн байгууллагыг дэмжих чиглэлээр төлөвлөгөөтэй арга хэмжээ авна.

14. Банкны бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно.

15. Банкны бүтэц тогтолцоог боловсронгуй болгож, хууль тогтоомжийг сахиулан, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, өрсөлдөөнийг дэмжихэд чиглэгдсэн банкны хувьчлалын зарчмыг баримтална.

16. Банкны бүртгэлийг олон улсын жишигт нийцүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, төлбөр тооцоонод компьютерийн дэвшилтэт программ хангамж нэвтрүүлнэ.

17. Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг олон улсын жишиг, өөрийн онцлогт нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн авна.

18. Банкны дотоод хяналтын тогтолцоог боловсруулан нэвтрүүлж, түүнд тавих хяналтыг Монголбанкнаас банкны үйл ажиллагаанд тавих хяналтын бүрэлдэхүүн хэсэг болгож хөгжүүлнэ.

19. Банкны санхүүгийн тайланд эрх бүхий аудитын байгууллагаас дүгнэлт өгөх журмыг тогтоож мөрдүүлнэ.

Валютын бодлогын талаар

20. Мөнгөний бодлогын үндсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төгрөгийн гадаад валютаар илэрхийлэгдэх нэрлэсэн болон бодит ханшийн өөрчлөлтийг бодлогын хэрэгслүүдээр хослуулан удирдаж хяналт тавих, гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн нөлөөллийг харгалзан зохицуулах чиглэлийг баримтална.

21. Энэхүү төлөвлөгөөний 20-д заасан чиглэлийг баримтлахдаа төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн чөлөөтэй хөвөх тогтолцоог хэвээр хадгалж, түр зуурын хэлбэлзлийг багасгахас өөрөөр гадаад валютын зах дээр Монголбанкнаас оролцохыг хязгаарлана.

22. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг бодитой байлгах үүднээс түүнийг тооцох аргачлалыг боловсронгуй болгон, мэдээллийн хамрах хүрээг өргөжүүлнэ.

23. Гадаад валютын улсын цэвэр нөөцийг 1998 оны эцэст 80 сая америк долларт байлгана.

24. Гадаад валютын улсын нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдал, орлогын шалгуур үзүүлэлтийг тогтоон мөрдүүдэж, активын болон эрсдлийн удирдлагын дэвшилтэт хэрэгслийг нэвтрүүлнэ.

25. Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх төрлийн төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэж байх журмыг үргэлжлүүлэн мөрдүүлнэ.

26. Банк хоорондын валютын зах зээлийг хөгжүүлэх зорилгоор итгэлцлийг бэхжүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

Хуулийн төслийг санаачлагчид нь
буцах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 5-г үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1997 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан Хүнсий тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагч болон холбогдох Байнгын хорооны санааг үндэслэн дахин боловсруулахаар хууль санаачлагчид нь буцласугай.

ДЭД ДАРГА

Ц.ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 12 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 91

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтайванаас 1997 оны 6 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн "Зарим бараанд экспортын галлийн татвар ногдуулах тухай хууль нэмэлт оруулах тухай" хуулийн төслийг ой модны аж үйлдвэр түшиглэн байгуулагдсан хот суурингийн хүн амын нийгмийн хамгаалалын асуудлыг нягтлан судлах, Засгийн газрын гишүүд болон яамдын санал, дүгнэлтийг тодорхой гаргуулах шаардлагатай гэсэн үндэслэлээр хуралдаана оролцсон гишүүдийн олонхийн саналаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж хуулийн төслийг санаачлагчид нь буцаасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1997 оны 12 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 92

Улаанбаатар
хот

Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Улсын Их Хурлын гишүүн Н.Түвшинтөгсийн 1997 оны 6 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн "Эрчим хүчний хэмжээний төслийг хэрэгжүүлэх зээлийн хэлэлцээрийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим эрэг хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх уг тогтоолын төсөл дурдсан явдлууд нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1998 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан, зарим шалтгааныг Дэд бүтцийн хөгжлийн сайдын тушаалаар олоо сэрэгжүүлж байгаа зэрэг үндэслэлээр хуралдаана

оролцсон гишгүүдийн олонхийн саналаар уг тогтоолын төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж төслийг санаачлагчид нь буцаасутай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1997 оны 12 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 93

Улаанбаатар
хот

Хууль хэрэгжүүлэх зарим арга
хэмжээний тухай

Ажлын таван өдөртэй долоо хоногт шилжүүлэх тухай болон Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1/Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай:

1/Монгол Улс ажлын таван өдөртэй долоо хоногт шилжсэнээр иргэдийн чөлөөт цагийг нэмэгдүүлэн, ашиглалтыг нь сайжруулах, иргэдийн оюуны болон биеийн хүчигээ хөгжүүлэх, нөхөн сэргээх, эрүүл мэндээ хамгаалах, мэдлэг, боловсрол, ур чадвараа дээшлүүлэх, мэргэжил эзэмших, үр хүүхдээ сургаж хүмүүжүүлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зэрэг хүний өгжлийн ихээхэн нөөц, бололцоо бий болж байгааг олон нийтэд илгүүдэх, сурталчлах талаар олон төрөл, хэлбэрийн ажил зохион байгуулах;

2/Энэ тогтоолын 1.1-д заасан хүний хөгжлийг хангахад нилэгдсэн зорилтуудыг хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог бий болгох, ажлын таван өдөрт шилжих явдлыг бүтцийн өөрчлөлт, хөдөлмөр-юхион байгуулалтын болон бусад арга хэмжээтэй уялдуулан тогцолбороор авч хэрэгжүүлэх;

3/Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, гал түймэртэй эмцэх байгууллага болон тасралтгүй ажиллагаатай бусад байгууллага, аж ахуйн нэгжид ажиллагчдын ажлын онцлогтой холбоотойгоор эдний ажил, амралтыг зохистойгоор хуваарилах арга хэмжээ авах;

4/Долоо хоногийн амралтын өдрүүд дараалсан байх зарчимд нийцүүлэн бүх шатны сургуулийн ажил, амралтын хуваарийг охицуулах.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар
хот

**МУИС-ийн зарим багшид Монгол Улсын
гавьяат багш цол хүртээх тухай**

Боловсролын байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж
их, дээд сургуулийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй
болгох, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, сургалтын гарын
авлага, ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл туурвих
үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын Их
сургуулийн дор дурдсан багш нарт Монгол Улсын гавьяат багш цол
хүртээсүгэй.

- | | |
|-----------------------|--|
| 1. Цэдэнгийн Жамсран | -МУИС-ийн биологийн тэнхимийн
эрхлэгч |
| 2. Гомбын Миеэгомбо | -МУИС-ийн Эдийн засгийн дээд
сургуулийн зөвлөх багш |
| 3. Осорын Шагдарсүрэн | -МУИС-ийн амьтан судлалын
тэнхимийн багш |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

**С.Цэвэлмаад Монгол Улсын гавьяат
жүжигчин цол хүртээх тухай**

Урлаг, соёлын байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж
дэлхийн сонгодог болон өөрийн орны хөгжмийн нэрт зохиолчдын
олон арван бүтээлийг хийл, хуучир хөгжмөөр чадварлаг тоглож, соёл
урлагийн боловсон хүчин бэлтгэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Хөгжим бүжгийн коллежийн багш Сундуйн Цэвэлмаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

Д.Сүхэд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын
гавьяат ажилтан цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж Халдвартын клиникийн эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэх, хамт олныг удирдан зохион байгуулах, боловсон хүчний мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, халдварт болон гоц халдварт өвчнийг анагаах, урьдчилан сэргийлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Халдвартын клиникийн эмнэлгийн захирал, ерөнхий эмч Дамчайн Сүхэд Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

МУИС, Хөгжим, бүжгийн коллежийн
зарим багшийг одон, медалиар
шагнах тухай

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан багш нарыг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

- | | |
|-------------------------|---|
| 1. Рэнчинхандын Балдорж | -МУИС-ийн биохими-микробиологийн тэнхмийн эрхлэгч |
| 2. Самдангийн Дашдаваа | -МУИС-ийн геологийн тэнхмийн эрхлэгч |
| 3. Намдагийн Дащэрэн | -Хөгжим, бүжгийн коллежийн багш |

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

- | | |
|------------------------------|---|
| 1. Цэрэндоржийн Дащдорж | -МУИС-ийн алгебрын тэнхмийн эрхлэгч |
| 2. Алтангэрэлийн Доржпалам | -МУИС-ийн Ерөнхий химийн тэнхмийн эрхлэгч |
| 3. Энхбаярын Равдан | -МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн слав судлалын тэнхмийн эрхлэгч |
| 4. Цэнднямын Сумъяа | -МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн англи судлалын тэнхмийн эрхлэгч |
| 5. Дащдаваагийн Хүүхэнбаатар | -МУИС-ийн түүхийн тэнхмийн багш |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

- | | |
|--------------------------|--|
| 1. Жамсрангийн Дагвадорж | -МУИС-ийн Монголын судлалын дээд сургуулийн утга зохиолын багш |
| 2. Нацагийн Хавх | -МУИС-ийн Нийгмийн ухааны факультетийн философийн тэнхмийн эрхлэгч |
| 3. Шаравын Чоймал | -МУИС-ийн Монголын судлалын дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

**Н.Бүтэнбаярыг "Алтан гадас"
олонгоор шагнах тухай**

Мэргэжлийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж дотоод, гадаадын хөгжмийн зохиолчдын олон бүтээлийг удирдан тоглуулж, хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын филармонийн симфони найрал хөгжмийн уран сайхны удирдагч, ерөнхий удирдагч Намсрайжавын Бүтэнбаярыг "Алтан гадас олонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар
хот

**Т.Нармандахыг Цэргийн гавьяаны
олонгоор нэхэн шагнах тухай**

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахуулах үүргээ гүйцэтгэн, төр засаг, ард түмэндээ өргосөн тангарагаа үнэнчээр биелүүлж яваад гэмт этгээдүүдийн халдлагад өртөж алтан амиа алдсан, Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ажилтан ахлах дэслэгч Тогоочийн Нармандах агсныг Цэргийн гавьяаны олонгоор нэхэн шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар
хот

**Л.Шижирболдыг Цэргийн хүндэт
медалиар шагнах тухай**

Монгол Улсын дархан хилийг зөрчсөн гадаадын иргэдийг илрүүлж, саатуулж баривчлахад эрэлхэг зориг гарган тэмцэж хил хамгаалах албан үүргээ нэр төртэй биелүүлснийг нь үнэлж Дорнод аймаг дахь Хилийн цэргийн 0198 дугаар ангийн хилчин байлдагч Лхагвасүрэнгийн Шижирболдыг Цэргийн хүндэт медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 11 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар
хот

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн
гишүүний тухай**

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн зарлиг болгох нь:

Чимиддоржийн Амарболдыг Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилж, Балчингийн Цэрэндоржийг шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар
хот

**Р.Самжидал Монгол Улсын урлагийн гавьяат
зүтгэлтэн цол хүртээх тухай**

Урлаг соёлын байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажиллаж, монголын олон үндэстэн ястны уламжлалт бүжиг дэглэх, бүжиглэх, залуу бүжигчдийг сургаж бэлтгэх, орон нутагт үндэсний урлаг соёлыг хөгжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баян-Өлгий аймгийн Соёл үйлчилгээний төвийн захирал Риймэдийн Самжидал Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

**Ц.Батнасанд Монгол Улсын гавьяат
багш цол хүртээх тухай**

Боловсролын байгууллагад үр бүтээлтэй, санаачилгатай ажиллаж сурагчдын авьяасыг нээж хөгжүүлэх, тэдэнд мэргэжлийн чиг баримжда олгох, шавь төвтэй сургалт зохион байгуулж, өсвөрийн залуу үеийг сурган хүмүүжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Увс аймгийн Боловсрол төвийн захирал Цэрэнгийн Батнасанд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот

**А. Думбурай, М. Лхамсүрэн нарыг
Сүхбаатарын одонгоор шагнах
тухай**

Монгол Улсын анхдугаар Үндсэн хууль батлагдаж, БНМАУ-ыг тунхагласны 73 жилийн ойг тохиолдуулан цагдаагийн байгууллагад олон жил идэвх зүтгэлтэй ажилласан дор дурасан хүмүүсийг Сүхбаатарын одонгоор шагнасугай.

- | | |
|---------------------------|---|
| 1. Алтангэрэлийн Думбурай | -Цагдаагийн ерөнхий газрын
ахмадын хорооны дарга |
| 2. Минжүүрийн Лхамсүрэн | -Цагдаагийн ахмад ажилтан |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

**Зарим хүнийг одон, медалиар
шагнах тухай**

Үйлдвэртэй, үйлчилгээ, боловсрол, төр захиргааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН
ТУГИЙН ОДОНГООР**

Лхамсүрэнгийн Энэбиш

-Нийслэлийн Бизнесийн холбоо-
ны тэргүүн

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

- | | |
|-----------------------------|---|
| 1. Ганхүүгийн Батбаяр | -Дархан-Уул аймгийн "Алтан түрүү" ХК-ийн ерөнхий захирал |
| 2. Гунгаагийн Бүдрагчаа | -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг дарга |
| 3. Лхамжавын Лхагвадолгор | -Нийслэлийн Баянгол дүүргийн 5 дугаар хорооны Засаг дарга |
| 4. Шагдарын Мижид-Очир | -Нийслэлийн 25 дугаар тусгай сургуулийн зөвлөх багш |
| 5. Донхорын Сумъяасүрэн | -Дундговь аймгийн Өлзийт сумын хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний "Тэсрээ" ХХК-ийн захирал |
| 6. Өлзийбадрахын Хоролдаваа | -Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Худалдааны техник" ХК-ийн дэд захирал |
| 7. Задийн Цэнгэлсайхан | -Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга |
| 8. Дамбийн Чинзориг | -Өмнөговь аймгийн худалдаа, үйлчилгээний "Малчин" компанийн ерөнхий захирал |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

- | | |
|-------------------|--|
| 1. Хаажингийн Бор | -Нийслэлийн 25 дугаар тусгай сургуулийн бага ангийн багш |
| 2. Дагвын Цээпээ | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бичээч |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар
хот

Зарим хүнийг одон, медалиар
шагнах тухай

Төвөөс алслагдсан баруун аймгуудад эрчим хүч, ой, ангийн аж ахуй ус цаг уурын албыг хөгжүүлэх болон төрийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон медалиар шагнасугай.

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

- | | |
|-----------------------|---|
| 1. Тавагийн Цагаанхүү | -Увс аймгийн эрчим хүчний барилга угсралтын 5 дугаар конторын дарга |
| 2. Цэдэн-Ишийн Ленаа | -Увс аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн техникч |
| 3. Жавааны Бадрах | -Ховд аймгийн Ой, ангийн аж ахуйн орлогч дарга |

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

- | | |
|------------------|---|
| Ахмадийн Лударин | -Баян-Өлгий аймгийн Баянтуг сумын иргэн, өндөр настан |
|------------------|---|

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

- | | |
|---------------------------|---|
| 1. Танхайн Айдас | -Баян-Өлгий аймгийн Эрчим хүчний барилга угсралтын дүгээр конторын монтёр |
| 2. Тилеухавалын Бердмурад | -Баян-Өлгий аймгийн Эрчим хүчний барилга угсралтын дүгээр конторын мастер |
| 3. Нанздын Нансалмаа | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын бичээч |

1. Жумдааны Буялжаргал - Увс аймгийн Эрчим хүчний барилга угсралтын 5 дугаар конторын краэчин
1. Авирмэдийн Чулуун - Ховд аймгийн Эрчим хүчний барилга угсралтын "Алтай" трестийн жолооч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 12 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

**С.Хундмаад Монгол Улсын гавьяат
агрономч цол хүртээх тухай**

Газар тариалангийн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж, өрс эдлэншүүлэх, үр суулгах, ургац хураах ажлыг технологийн дагуу анартай гүйцэтгэж, га-гаас авах ургацыг тогтвортой нэмэгдүүлэн эх рны гурилын хэрэгцээг хангах үйлст оруулж байгаа хувь нэмрийг ү үнэлж Сэлэнгэ аймгийн Цагаанцуур сумын "Товхонхан" ХК-ийн рөнхий агрономч Санжийн Хундмаад Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээсүтэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 12 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар
хот

**Д.Волоожид Монгол Улсын гавьяат
агрономч цол хүртээх тухай**

Хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний байгууллагад удаан жил үр үтээлтэй ажиллаж, төмс, хүнсний ногооны аж ахуйг хөгжүүлэх

шинжлэх ухааны үндэслэл, тариалалтын технологийг боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хүнсний нарийн ногооны олон сортыг шинээр гаргах, нутагшуулах, тээгээрийн үрийн хэрэгцээг хангах үйлэт оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Дашзэвэгийн Волоожид Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1997 оны 12 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Хөдөө аж ахуйн салбарын зарим хүнийг
одон, медалиар шагнах тухай

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурасан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН
ТУГИЙН ОДОНГООР**

- | | |
|-------------------------|---|
| 1. Нацагийн Дэлгэрмөрөн | -Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Товхонхан" ХК-ийн бригадын дарга |
| 2. Маналын Самдан | -Төв аймгийн Мал эмнэлгийн газрын дарга, ерөнхий эмч |
| 3. Нүсэвийн Сомо | -Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын "Ачит-Алхаб" ХК-ийн захирал |
| 4. Дэлгэрийн Түмэнбаяр | -Сэлэнгэ аймгийн Баянгол сумын "Хараа" ХК-ийн захирал |
| 5. Дэжидийн Цэнд-Аюуш | -Төв аймгийн Жаргалант сумын "Жаргалант" ХК-ийн бригадын дарга |

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

- | | |
|------------------------------|--|
| 1. Цэрэндоржийн Амиржаргал | -Төв аймгийн Сүмбэр сумын "Баялаг" ХК-ийн захирал |
| 2. Жүгдэрнамжилын Бямбасүрэн | -Төв аймгийн Жаргалант сумын "Жаргалант" ХК-ийн ногоочин |
| 3. Лхүндэвийн Давлажаргал | -Төв аймгийн Сүмбэр сумын "Өгөөж" ХК-ийн захирал |
| 4. Битеубайн Есимхэн | -Баян-Өлгий аймгийн Ногоонуур сумын "Ачит-Алжаб" ХК-ийн тракторч-комбайнч |
| 5. Байжамалын Катубай | -Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Товчооноо" ХК-ийн бригадын дарга |
| 6. Шаравын Марлаан | -Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Газрын ундраа" ХК-ийн захирал |
| 7. Шомбонгийн Орсоо | -Таримаа ургамлын үр, ургамлын хорно цэврийн хяналтын улсын төв лабораторийн захирал |
| 8. Луулуугийн Төмөрхуяг | -Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Ургамлын ундраа" ХК-ийн тракторч-комбайнч |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

- | | |
|--------------------------|---|
| 1. Дэнцэвийн Балжин | -Таримаа ургамлын үр, ургамлын хорно цэврийн хяналтын улсын төв лабораторийн жижүүр |
| 2. Доржпаламын Ганбат | - Сэлэнгэ аймгийн Орхон сумын "Орхон далай" ХК-ийн тракторч-комбайнч |
| 3. Жалбуугийн Давласүрэн | -Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Газрын ундраа" ХК-ийн тракторч-комбайнч |

- | | |
|--------------------------|---|
| 4. Балжирын Доржсүрэн | - Төв аймгийн Аргалант сумын "Нөхөрдөл" ХК-ийн тракторч-комбайнч |
| 5. Сүмбэрийн Ням-Очир | - Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Товхонхан" ХК-ийн тракторч-комбайнч |
| 6. Надмидын Өлзийхутаг | - Дорнод аймгийн Таримал ургамлын үр шинжилгээний лабораторийн эрхлэгч |
| 7. Садыбахасын Хамзархан | - Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын "Ачит-Алхаб" ХК-ийн тракторч |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1997 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Дугаар 213 Улаанбаатар хот

Ой тэмдэглэх тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсан 360 жилийн эг 1999 оны 10 дугаар сарын 29-ний өдөр эмдэглэсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд **М.ЭНХСАЙХАН**

Гэгээрлийн сайд **Ч.ЛХАГВААВ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1997 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Дугаар 219 Улаанбаатар хот

Сам байгуулах тухай

Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, илчилгээг сайжруулах, түүнийг санхүүжүүлэхэд иргэд, эрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх эрилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. "Сумын эрүүл мэндийн сан" байгуулан ажиллуулах ийтлэг журмыг хавсралтын ёсоор сайшаасугай.

2. Энэхүү журмын дагуу харьяа нутаг дэвсгэртээ игэдийн үүсгэл санаачилгын үндсэн дээр "Сумын эрүүл мэндийн сан" байгуулах ажлыг 1998 оноос эхлэн зохион ийгуулахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг илгосугай.

3. Сумын хүн амын эрүүл мэндийг сайжруулахад илхүүгийн дэмжлэг үзүүлэх байнгын эх үүсвэр бий илгох, бүрдсэн санг арвижуулах, зарцуулалтад хяналт

тавих ажлыг удирдан зохион байгуулахыг нийт сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөж болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХСАЙХАН

Эрүүл мэнд, нийгмийн
хамгааллын сайд

Л.ЗОРИГ

Засгийн газрын 1997 оны 219
дүгээр сэтгүүлн хавсралт

**"СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САН" БАЙГУУЛАН
АЖИЛЛУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

1.Орон нутагт ялангуяа, сумын тусамд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, эмнэлгийн багаж хэрэгсэл, уналгын хангамжийг сайжруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд хувь хүн, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах замаар "Сумын эрүүл мэндийн сан" /цаашид сан гэнэ/-г байгуулж, түүний үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2.Сумын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, эмнэлгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэсэн арга хэмжээ болон амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой өрхийн гниүүд, өндөр настан, тахир дутуугийн тэтгэвэр авагч иргэдэд эмлүүлэхээр явахад дэмжлэг үзүүлэхэд энэхүү сангийн хөрөнгийг зарцуулна.

3.Сумын хүн амын эрүүл мэндийг сайжруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх байнгын эх үүсвэр бий болгох, сангаа арвижуулах, зарцуулалтад хяналт тавих, удирдан зохион байгуулах тухай асуудлыг сумын Засаг даргын Тамгын газар боловсруулж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэртлүүлж байна.

4.Санг тухайн нутаг дэвсгэрийн хүн ам /хувь хүн, айл өрх/, аж ахуйн нэгж, байгууллагаас сайн дурмы үндсэн дээр өгөх хандив, тусламжаар бүрдүүлэн байгуулна.

5.Сан нь цаашид дараахь байнгын эх үүсвэрээс бүрдэнэ:

а/аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, хувь хүн, айл өрхөөс өгсөн хандив;

б/гадаад орон, олон улсын байгууллагаас өгсөн буцалтгүй тусламж;

в/бусад эх үүсвэр.

6.Тухайн сумын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг болон тус сумын эмнэлгээр үйлчлүүлдэг зэргэлдээ сумын хувь хүн, айл өрх /амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой өрхөөс бусад/ бэлэн мөнгө буюу мал аж ахуйн бүтээгдэхүүнээр санд хандив өргөж болно.

7.Сангийн хөрөнгийг /хэрэв бүтээгдэхүүнээр санд хандив өгсөн бол түүнийг борлуулж/ хадгаламжийн банкинд тусгай данс нээн төвлөрүүлнэ.

8.Сангийн хөрөнгийг дараахь арга хэмжээнд зарцуулна:

а/эмчилгээ, үйлчилгээг сайжруулах зорилгоор эмнэлгийн уналга, багаж хэрэгсэл худалдан авах;

б/орон нутагт эмч, эмнэлгийн бусад мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор урамшуулал олгох;

в/амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой өрхийн гивүүд болон өндөр настан, тахир дутуугийн тэтгэвэр авагчдыг аймаг, нийслэлд эмчийн заалтаар эмчлүүлэхээр явахад нь унааны зардлын хөнгөлөлт үзүүлэх;

г/санг удирдан зохион байгуулах, захиран зарцуулах, үр дүнг нэгтгэн тайлагнах үүргийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн дагуу байгуулагдсан Сангийн зөвлөл гүйцэтгэнэ. Уг зөвлөл нь төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл бүхий 3 гишүүнтэй байна.

10.Санг сумын эмнэлгийн төсвөөс тусгаар байлгах зөвхөн энэ журмын 8-д заасан зориулалтын дагуу зарцуулна.

11.Сумын Засаг даргын Тамгын газар Сангийн тайланг Сангийн зөвлөлөөр эмнэлгийн санхүүгийн тайлан тэнцлийг гаргах маягт, журмын дагуу улирал тутам гаргуулан авч жилийн эцэст нэгтгэж, эмнэлгийн тайлан тэнцэлд хавсаргах аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам аймгуудын тайланг жил бүр нэгтгэн дүн шинжилгээ хийж байна.

12.Сангийн зөвлөл нь сумын эрүүл мэндийн санг зориулалтын бус зүйлд зарцуулах, байгууллага, хүмүүст зээлдүүлэхийг хориглоно.

13. Сангийн зарцуулалттай холбогдон маргаан үүсвэл шүүхэд хандаж болно.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1997 оны 11 дүгээр Улаанбаатар
сарын 3-ны өдөр Дугаар 220 хот

Хөтөлбөрт зарим нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 1997 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчийг 1997-2000 онд хувьчлах хөтөлбөр (цаашид Хөтөлбөр гэх)-ийн "Нэг"-ийн 3-ын сүүлчийн догол мөр, 5-ын 1, 2 дахь заалт, "Дөрөв"-ийн 3-ын эхний хэсэг, "Тав"-ын 1, 2, 6, 13, "Зургаа"-гийн 4, 5, 10-ын гурав, дөрөв дэх догол мөр, 11-ийн "б" заалтын 2 дахь өгүүлбэр, "в" заалтын 2 дахь догол мөрийн сүүлчийн өгүүлбэр, 16-гийн 2 дахь өгүүлбэр, 17, 19-ийн "г" заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/"Нэг"-ийн 3-ын сүүлчийн догол мөр "Хувьчлагдах аж ахуйн нэгжийн талаархи мэдээллийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу зарлана."

2/"Нэг"-ийн 5-ын 1, 2 дахь заалт: "1. Жижиг аж ахуйн нэгжийг энэхүү хөтөлбөрийн "Тав"-д заасан үнийн саналаа хэлж дуудах нийтийн дуудлагын худалдааны журмын дагуу хувьчилна."

"2. Томоохон аж ахуйн нэгжийг энэхүү хөтөлбөрийн "Зургаа"-д заасан битүүжилсэн хэлбэрээр санал авах дуудлагын худалдааны журмын дагуу хувьчилна."

3/"Дөрөв"-ийн 3-ын эхний хэсгийг "3. Зөвхөн дараахь нөхцөлийг хангасан тохиолдолд хувьчлах аж ахуйн нэгжийн жагсаалтад Засгийн газраас өөрчлөлт оруулж, энэ тухай шийдвэрийг "Засгийн газрын мэдээ" сонинд бүрэн эхээр нь нийтлэнэ;"

4/"Тав"-ын 1, 2, 6, 13: "1 дүгээр жагсаалтад заагдсан жижиг аж ахуйн нэгжүүдийг үнийн саналаа хэлж дуудах нийтийн дуудлагын худалдааны хэлбэрээр хувьчлахад энэ журмыг мөрднө."

1. Дуудлагын худалдаанд хойроос доошгүй этгээд оролцсоноор хүчин төгөлдөр болно."

"2. Дуудлагын худалдаанд хувьчлах эд хөрөнгийг худалдаж авах бие даасан саналтайгаар хуулийн дагуу оролцож байгаа этгээдийг "дуудлагын худалдаанд оролцогч" гэнэ.

Дуудлагын худалдаанд Монгол Улсын иргэн, гадаадны харьяат, харьяалангүй хүн, түүнчлэн Монголын болон гадаадны хуулийн этгээд оролцож болно.

Дуудлагын худалдаанд оролцогч харьяалангүй хүн гадаадны иргэний нэгэн адил, гадаадны хөрөнгө оруулалттай хуулийн этгээд гадаадны хуулийн этгээдийн нэгэн адил эрх зүйн байдалтай оролцоно."

"6. Дуудлагын худалдаанд дэнчин тавих, төлөх, энэ тухай баримтыг тушаах журмыг Төрийн өмчийн хорооноос баталж мөрдүүлнэ."

"13. Аж ахуйн нэгжийн төрийн өмчийн хувийг худалдсанаар олох орлогын доод хэмжээг дараахь журмаар тодорхойлно:

а/Монголын хөрөнгийн биржээр хувьцааг нь худалдаж байгаа төрийн өмчийн оролцостой аж ахуйн нэгжийн хувьд түүнийг худалдсанаас олох орлогын доод хэмжээ нь 1996 оны 7 дугаар сарын 3-ны өдрөөс 1997 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хоорондох хугацаанд Хөрөнгийн биржээр арилжаалагдаж байсан тухайн аж ахуйн нэгжийн нэгж хувьцааны хамгийн доод үнийг худалдагдах нийт хувьцааны тоогоор үржүүлсэн дүнтэй тэнцэнэ;

б/төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьд дуудлагын худалдаанаас олох орлогын доод хэмжээ нь тухайн аж ахуйн нэгжийн 1996 оны санхүүгийн жилд олсон цэвэр ашигтай тэнцүү байна;

в/1996 оны санхүүгийн жилд алдагдалтай ажилласан төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьд дуудлагын худалдаанаас олох орлогын доод хэмжээ нь 1 төгрөг байх бөгөөд түүний нэгж хувьцааны доод үнэ нь 0 төгрөгтэй тэнцүү байна."

5/"Зургаа"-гийн 4, 5:

"4. Битүүжилсэн дуудлагын худалдааг явуулахад энэхүү Хөтөлбөрийн "Тав"-ын 1, 2, 3, 4, 6-д заасан журам, шаардлагыг баримтлах бөгөөд оролцогчийн тавих дэнчингийн хэмжээг тогтоох шалгуур, журмыг Төрийн өмчийн хорооноос баталсан заавраар тодорхойлно."

"5. Оролцогч нь үнийн саналаа Төрийн өмчийн хорооны зааварт тусгагдсан аргачлал болон хугацааны дагуу

гаргана.Оролцогч бүр 15-аас илүү үнийн санал гаргах болохгүй."

6/"Зургаа"-гийн 10-ын гурав, дөрөв дэх догол мөр:

"*зах зээлийн клирингийн үнэ - нийт хувьцаа бүрэн худалдагдах боломжтой хамгийн дээд үнэ;

*хяналтын үнэ - нийт хувьцааны 50 буюу түүнээс дээш хувь нь зарагдах хамгийн дээд үнэ;"

7/"Зургаа"-гийн 11-ийн "б" заалтын хоёр дахь өгүүлбэр:

"Худалдагдаагүй үлдэх хувьцааг шалгарсан санал бүрт тэдний тохирсон анхны санал болгосон хувьцааны тоогоор хувь тэнцүүлэн үнэгүй хуваарилна;"

8/мөн "в" заалтын 2 дахь догол мөрийн сүүлчийн өгүүлбэр:

"Ням үнэтэй тэнцүү буюу түүнээс давсан бүх саналууд захиалсан хэмжээнийхээ хувьцааг авах эрхтэй болох бөгөөд үлдэх хувьцааг дээрх санал тус бүрт анхны хүссэн тоо хэмжээнд хувь тэнцүүлэн үнэгүй хуваарилна;"

9/"Зургаа"-гийн 16-гийн хоёр дахь өгүүлбэр:

"Дахин дуудлагын худалдааг анхны худалдаа явагдсан өдрөөс хойш 2 сарын дотор зарлана."

10/"Зургаа"-гийн 17, 19-ийн "г" заалтыг:

"17.Хэрэв нийт олох орлого нь тухайн аж ахуйн нэгжийг худалдсанаар олох орлогын доод хэмжээнд хүрээгүй байвал уг объектыг анхны битүүжилсэн дуудлагын худалдаагаар худалдаагүйд тооцно. Дахин дуудлагын худалдааг анхны худалдаа явагдсан өдрөөс хойш 2 сарын дотор зарлана."

"19.г/хуваарилагдаагүй үлдсэн бүх хувьцаа буюу тэдгээрийн аливаа үлдсэн хэсгийг энэ зүйлийн "а", "б", "в"-д дурдсан дарааллын дагуу оролцогчдод дуудлагын худалдааны үнээр худалдана."

2.Мөн хөтөлбөрийн "Долоо"-д дор дурдсан агуулгатай 9-ийг нэмсүгэй:

"9.Хувьчлагдах хөрөнгө эзэмшиж буй улсын үйлдвэрийн газар нь тухайн хөрөнгийн талаар эсрэг саналтай байгаа тохиолдолд улсын үйлдвэрийн газрын байр суурь, үүнтэй холбогдох бүх мэдээллийг "Засгийн газрын мэдээ" сонинд хэвлэнэ.Сонинд мэдээллийг нийтлэхтэй холбогдон гарсан зардлыг Төрийн өмчийн хороо болон эсрэг байр суурь бүхий тал нь тавь, тавин хувиар хуваан төлнө. Тухайн хөрөнгийг эзэмшиж буй улсын үйлдвэрийн газрын хувьчлалын эсрэг байр сууринд харуу өгөхөд Төрийн өмчийн хороо нь уг хөрөнгийг

хувьчлах санал гаргасан этгээдийг оролцуулах бөгөөд сонирхогч бүх талуудад 2 долоо хоногийн хугацаа олгоно."

3.Мөн хөтөлбөрийн "Зургаа"-гийн 3-аас " . . . хөндлөнгийн . . ." гэсэн үгийг хасч, "Тав"-ын 5, "Ес"-ийн 9-ийн "е" заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХСАЙХАН

Сангийн сайд

П.ЦАГААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1997 оны 11 дүгээр
сарын 3-ны өдөр

Дугаар 221

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Хувьчлагдах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, тэдгээрийн хөрөнгө, хувьцаа, ногдол хувийг худалдах доод үнийг магадлан тогтоох комисс, түүний ажиллах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХСАЙХАН

Сангийн сайд

П.ЦАГААН

Засгийн газрын 1997 оны 221
дүгээр тогтоолын хавсралт

**ХУВЬЧЛАГДАХ ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН
ӨМЧИЙН ОРЛОЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТЭД-
ГЭЭРИЙН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА, НОГДОЛ ХУВИЙГ
ХУДАЛДАХ ДООД ҮНИЙГ МАГАДЛАН ТОГТООХ
КОМИСС, ТҮҮНИЙ АЖИЛЛАХ ЖУРАМ**

1. "Төрийн өмчийн 1997-2000 онд хувьчлах хөтөлбөр"-ийн "Тав"-ын 14-т заасан журмын дагуу хувьчлагдах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн худалдах доод үнийг тодорхойлох боломжгүй онцгой тохиолдолд уг доод үнийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, тэдгээрийн хөрөнгө, хувьцаа, ногдол хувийг худалдах доод үнийг магадлан тогтоох комисс (цаашид "комисс" гэх) тогтоосно.

2. Магадлан тогтоох комисс дараахь бүрэлдэхүүнтэй байна:

Комиссын дарга	- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
Комиссын гишүүд:	- Ерөнхий сайдын өмч хувьчлалын асуудал эрхэлсэн зөвлөх; - Монголын хөрөнгийн биржийн захирал; - Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга; - Оюуны өмчийн газрын дарга.
Комиссын нарийн бичгийн дарга	- Төрийн өмчийн хорооны бич хувьчлалын газрын дарга

3. Доод үнийг нь комиссоор тогтоолгох шаардлагатай аж ахуйн нэгжийн жагсаалтыг Төрийн өмчийн хорооноос уг комисст ирүүлнэ.

4. Комисс дараахь асуудлыг шийдвэрлэнэ:

1. Төрийн өмчийг 1997-2000 онд хувьчлах хөтөлбөрний дагуу аж ахуйн нэгжүүдийн 10 хүртэлх хувь

Багтаан дор дурдсан нөхцөлд хамаарах аж ахуйн нэгжүүдийн доод үнийг тогтооно:

-Засгийн газар хоорондын хэлэлцээрээр байгуулагдсан хамтарсан үйлдвэрүүд;

-Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжүүд;

-үндсэн үйл ажиллагааны бус хэлбэрээр 1996 онд ашиг олсон аж ахуйн нэгжүүд;

-баландаа өртэй боловч харилцах дансандаа аль нэг хэлбэрээр их хэмжээний бэлэн мөнгөтэй, мөн бэлэн мөнгөнд хувирах боломжтой бараа бүхий аж ахуйн нэгжүүд;

-төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчлөлийн ногдол хувийг худалдах үнэ.

Б/хөтөлбөрт тусгагдсан аж ахуйн нэгжүүдийн ажиллагсдын тоонд өөрчлөлт орох шаардлагатай тохиолдолд Комисс шийдвэр гаргана;

в/Комиссоос гаргасан шийдвэрийг Төрийн өмчийн хороонд хүргүүлж, Монгол Улсын Засгийн газарт танилцуулна;

г/Комисс шаардлагатай гэж үзвэл "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 50, 54 дүгээр зүйлд заасны дагуу шинжээчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргах болно;

д/магадлан тогтоох комисс нь үйл ажиллагааны тайлангаа хагас жилд нэгээс доошгүй удаа Засгийн газарт оруулж хэлэлцүүлнэ.

5.Магадлан тогтоох комиссын үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг өмч хувьчлалын зардлаас санхүүжүүлнэ.

6.Магадлан тогтоох комиссын гаргасан шийдвэрийг Төрийн өмчийн хороо баримтлан үйл ажиллагаа явуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 11 дүгээр Улаанбаатар
сарын 12-ны өдөр Дугаар 225 хот

Тогтоол хүчингүй болсонд
тооцож тухай

Төрийн бус байгууллагын тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Журам батлах тухай" Засгийн газрын 1993 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 179 дүгээр тогтоол, "Заавар батлах тухай" Засгийн газрын 1995 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 161 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХСАЙХАН

Хууль зүйн сайд

Ж.АМАРСАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1997 оны 11 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 226

Улаанбаатар
хот

"Тогтвортой байдлын гэрээ"-ний
загвар батлах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Тогтвортой байдлын гэрээ"-ний загварыг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХСАЙХАН

Сангийн сайд

П.ЦАГААН

Засгийн газрын 1997 оны 226
дугаар тогтоолын хавсралт

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ГЭРЭЭ

Монгол Улсын ашигт малтмалын тухай хуулийн 20, 21 дүгээр зүйлийг үндэслэн нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Сангийн сайд /цаашид "сайд" гэнэ/, нөгөө талаас тогтвортой байдлын тухай гэрээ байгуулахаар хүсэлт гаргасан,-----
- унсад үүсгэн байгуулагдсан, ----- тоот
бүртгэлийн гэрчилгээтэй, ашигт малтмал ашиглах-----

----- дугаарын лиценз эзэмшигч -----
Компани/----- улсын иргэн ----- /цаашид
"Компани" эсхүл "Иргэн" гэнэ/-тэй үйл ажиллагаа
явуулах орчмыг нь урт хугацаанд тогтвортой байлгах
Баталгаа болгох энэхүү гэрээг байгуулав.

Наг.Гэрээгээр зохицуулах зүйл

1.1 Энэ гэрээгээр-----улсын-----Компани /Иргэн/
-----Монгол Улсын-----аймгийн-----сумын
-----газарт-----хорилгоор ашигт
малтмалын -----орчмыг ашиглах,-----төсөл
хэрэглүүлэх хугацаанд татварын тогтвортой нөхцөлийг
кангах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ олон улсын зах
зээлийн үнээр чөлөөтэй борлуулах, үүнээс олсон чөлөөт
валютын орлогоо захиран зарцуулах эрхийн баталгаагаар
кангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр.Үндсэн нөхцөл

2.1 Ашигт малтмал ашиглах лиценз эзэмшигч Компани
/Иргэн/-ий Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн төслийн
эхний 5 жилд оруулах анхны хөрөнгө оруулалтын хэмжээ
2 сая ам.доллараас багагүй байна.

2.2 Компани /Иргэн/-ий төлбөл зохих аж ахуйн
тэгжийн орлогын албан татварыг-----хувь,импортын
Зарааны гаалийн татварыг---- хувь,импортын болон
дотоодод борлуулсан барааны худалдааны /эсвэл түүнтэй
идилтгах/ албан татварыг ----- хувь буюу энэхүү гэрээ
сүчин төгөлдөр болох өдөр үйлчилж буй хууль
тогтоомжид заасан хувь хэмжээнд байлгана.

2.3 Компани /Иргэн/ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ
экспортлоход экспортын татвар-----,худалдааны /эсвэл
түүнтэй адилтгах/ албан татвар-----хувьнаар ногдуулна.
Гэрээ Компани /Иргэн/ нь алт олборлох Монгол Банк
эсхүл арилжааны аль нэг банкинд борлуулсан бол 10
сүвийн худалдааны /эсхүл түүнтэй адилтгах/ албан
татвар төлнө.

2.4 Компани /Иргэн/-ий төлбөл зохих ашигт
малтмалын нөөц ашигласны төлбөрийг гэрээ хүчин
төгөлдөр болох үед мөрдөгдөх байгаа ашигт малтмалын
олбогдолтой харилцааг зохицуулж буй хуульд заасан
хэмжээгээр төснө.

2.5 Компани үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортод
аргах, олон улсын зах зээлийн үнээр борлуулах,

үүнээс олсон чөлөөт валютын орлогоо захиран зарцуулахад нь энэ талаар Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд олгодогтой адил эрх, нөхцөлөөр хангана.

2.6 Компани /Иргэн/ нь энэхүү гэрээний 4.2, 4.3-т заасан хэмжээ, хугацаанд хөрөнгө оруулахаар хүлээсэн үүргээ биелүүлэлгүй 6 сар хэтрүүлсэн тохиолдолд энэхүү гэрээ хүчингүй болсонд тооцогдоно.

Гурав. Гэрээний хугацаа

3.1 Гэрээг 19--оны---дүгээр сарын----ны өдрөөс эхлэн 20---оны --- дүгээр сарын ----ны өдрийг хүртэл -----хугацаагаар байгуулав.

Дөрөв. Компани/Иргэн/-ий үүрэг, эрх

4.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, Монгол Улсын хууль тогтоомжийг дагах мөрдөнө.

4.2 Компани /Иргэн/ нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр энэхүү гэрээнд гарын үсэг зурснаас хойш--- жилийн хугацаанд -----сая ам.доллараас багагүй хөрөнгө оруулалт хийнэ.

Хөрөнгө оруулалтыг бэлэн мөнгө, технологи, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материалаар хийж болно.

4.3 Хөрөнгө оруулалтыг дараахь хуваарийн дагуу хийнэ:

№	Он, сар	Мөнгөний дүн мян.ам.дол/	Мөнгөн хэлбэрээр	Бусад хэлбэрээр
1	19-- оны---р сард			
2	19-- оны---р сард			
3	19-- оны---р сард			
4	200--оны---р сард			
5	200--оны---р сард			

Компани /Иргэн/ тухайн жилд төлөвлөснөөс илүү хөрөнгө оруулалт хийсэн нөхцөлд давсан хэсгийг дараагийн жилийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд оруула тооцно.

4.4 Компани /Иргэн/ нь тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалтын тайланг энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн өдрөөс хойш жил бүр тухайн

хилийн дараагийн сард багтаан Сангийн яамнаас баталсан маягтын дагуу гаргах, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраар хянуулан Сангийн сайдад ирүүлж байна.

4.5 Компани /Иргэн/ нь бүтээгдэхүүнээ борлуулснаас олсон орлогоо Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй аль нэг арилжааны банкинд нээсэн дансанд эхлэн байршуулна.

4.6 Сайд энэхүү гэрээгээр хариуцсан үүргээ биелүүлээгүйн улмаас Тогтвортой байдлын гэрээний баталгаа алдагдсан төхиолдолд Компани /Иргэн/ нь баталгааг сэргээлгэх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр хуульд заасан журмын дагуу нэхэмжлэх эрх эдэлнэ.

Тав. Сайдны үүрэг, эрх

5.1 Компани үйл ажиллагаагаа явуулах орчимг нь урт хугацаанд тогтвортой байлгах талаар энэхүү гэрээнд заасан баталгаа, нөхцөлөөр хангах явдлыг хариуцна.

5.2 Тогтвортой байдлын гэрээнд гарын үсэг зурсны дараа уг гэрээний нөхцөлийн тухай мэдэгдлийг Монгол Банк болон холбогдох газруудад хүргүүлнэ.

5.3 Компани /Иргэн/ нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсвэл Монгол Улсын хуулийг ноцтой зөрчсөн нь нотлогдвол Сайд энэ тухай Компанид албан мэдэгдэл өгч гэрээг дангаар цуцална.

Зургаа. Вусад зүйл

6.1 Гэрээний үүргийн биелэлттэй холбогдон ямар нэг маргаантай асуудал үүсвэл талууд аль болох хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэнэ. Нэгдсэн шийдэлд хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль болон олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.

6.2 Гэрээг 19--оны---дугаар сарын ----ны өдөр Улаанбаатар хотод монгол, англи хэл дээр тус бүр 2 хувь үйлдэж талууд нэг нэг хувийг хадгалав.

Монгол Улсын Засгийн
газрыг төлөөлж:

сайд-----П.ЦАГЛАН

компанийг төлөөлж:

Гарын үсэг-----

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1997 оны 11 дүгээр
сарын 12-ны өдөр Дугаар 229

Улаанбаатар
хот

Хөтөлбөр өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТӨГТӨӨХ нь:

1. Засгийн газрын 1997 оны 150 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 1997-2000 онд хувьчлах хөтөлбөр"-ийн хувьчлах жижиг болон томоохон аж ахуйн нэгжүүдийн жагсаалтаас 1 дүгээр хавсралтад заасан аж ахуйн нэгжүүдийг хассугай.

2. Мөн жагсаалтад 2 дугаар хавсралтад заасан аж ахуйн нэгжүүдийг нэмж оруулсугай.

3. "Дорнод гуриг" ХХ, "Хөдөөгийн тээвэр" ХҮ-ийн төрийн өмчлөлийн хувьцааг нийтийн дуудлагын худалдаагаар хувьчлахыг Төрийн өмчийн хөрөнгө дарга З. Энхболдод зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

М. ЭНХСАЙХАН

Сангийн сайд

П. ЦАГААН

Засгийн газрын 1997 оны 229 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

**"ТӨРИЙН ӨМЧИЙГ 1997-2000 ОНД ХУВЬЧЛАХ
ХӨТӨЛБӨР"-ИЙН ЖИЖИГ БОЛОН ТОМООХОН АЖ
АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТААС ХАСАГДАХ
АЖ АХУЙН НЭГЖҮҮД**

ХОЙР. Хувьчлах жижиг аж ахуйн нэгжүүд

/1 дүгээр жагсаалт/

А. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Байгуул- лагын нэр	Төрийн өмчийн эзлэх хувь	Ажил- лагчдын тоо
6	Баян-өлгий	Өлгий	Асгатын уулын үйлдвэр ХХ	51	34

25	Дархан-уул	Дархан-уул	Материал импекс ХК	51	11
53	Завхан	Улиастай	Завхан тээвэр ХК	51	48
54	Завхан	Улиастай	Завхан тээх ХК	51	50
58	Өвөрхангай	Арвай-хээр	Разно-импекс ХК	51	42
40	Ховд	Жаргалан	Минж өргөө ХХК	49	5

Б. Улсын үйлдвэрийн газрууд

1	Архангай	Бат-цэнгэл	Халаалтын зуух	100	12
3	Архангай	Тарнат	Уурын зуух	100	6
4	Архангай	Тарнат	Залуусын жавхлаа	100	4
8	Архангай	Эрдэнэ-булган	"Архангайн үнэн" сонин үйлдвэр	100	15
12	Баян-өлгий	Өлгий	Нийтийн үйлчилгээний алба	100	36
13	Баян-өлгий	Өлгий	Хус ОСА контор	100	24
15	Баян-өлгий	Өлгий	Радио нэвтрүүлгийн редакци	100	16
17	Баян-өлгий	Өлгий	Хот тохижуулах алба	100	12
21	Баян-өлгий	Өлгий	Хана-Өмир сонин газар	100	5
24	Баян-өлгий	Өлгий	ХАА-н даатгал	100	1
27	Баянхонгор	Баянхонгор	Чандмань компани	100	50
33	Баянхонгор	Баянхонгор	Хэвлэл мэдээллийн алба	100	5
34	Баянхонгор	Баянхонгор	Эрдэйн ундраа брокерийн пүүс	100	4

35	Баянхонгор	Баян-хонгор	Давс УУГ	100	3
44	Булган	Булган	ХАА-н даатгал	100	5
45	Булган	Булган	Барилга захиалагчийн товчоо	100	2
49	Булган	Хялганат	Ус суваг	100	32
51	Говь-алтай	Есөн-булаг	Хот тохижуулах анги	100	18
52	Говь-алтай	Есөн-булаг	Ус суваг ашиглалтын анги	100	42
56	Говь-алтай	Есөн-булаг	Монгол даатгал компанийн салбар	100	14
58	Говь-алтай	Есөн-булаг	Хэвлэл мэдээллийн нэгдсэн алба	100	11
71	Дархан-уул	Дархан-уул	Хэвлэл мэдээллийн нэгдсэн редакци	100	35
74	Дархан-уул	Дархан-уул	Барын голын ОСНАА газар	100	26
79	Дархан-уул	Дархан-уул	Хүнс, ХАА-н даатгал компанийн салбар	100	11
80	Дархан-уул	Дархан	Монгол даатгал компанийн салбар	100	8
92	Дорнод	Баян-уул	Оян аж ахуй	100	15
93	Дорнод	Баян-уул	Улзын гэгээ компани	100	8
94	Дорнод	Баян-түмэн	Сүлд мод компани	100	5
95	Дорнод	Булган	Хавхлант-		

			гэрэл компани	100	8
96	Дорнод	Гурван- загал	Вулан цагаан компани	100	10
97	Дорнод	Дэлбэл- бар	Түрийн толго компани	100	2
98	Дорнод	Натад	Ундрах гэрэл компани	100	2
99	Дорнод	Сэргэлэн	Ямз компани	100	6
101	Дорнод	Халх гол	Долгион	100	2
102	Дорнод	Халх гол	Халх эрчим компани	100	1
103	Дорнод	Хөлөн- буйр	Барга хонь УУГ	100	9
105	Дорнод	Хэрлэн	Хэвнэл мэ- дрэллийн төв	100	22
109	Дорнод	Хэрлэн	Даатгал ХАА-н салбар	100	6
110	Дорнод	Хэрлэн	Дорнин зуух компани	100	4
113	Дорнод	Цагаан- овоо	Ильичийн гэрэл компани	100	7
114	Дорнод	Чойбал- сан	Талхи гэрэл компани	100	6
115	Дорнод	Чойбал- сан	Өнгөт өд УУГ	100	1
116	Дорнод	Чулуун- хороот	Дэлбэрэлт компани	100	4
117	Дорнод	Чулуун- хороот	Ангирт УУГ	100	2
125	Дундговь	Мандаг- говь	ХАА-н даатгал	100	3
126	Дундговь	Мандаг- говь	Барилга захирал- чийн товчоо	100	2
134	Завхан	Улиастай	Хот тохи- жуулах	100	37

			алба		
140	Завхан	Улиастай	Кино үзвэр	100	5
141	Завхан	Улиастай	ХАА-н даатгалын салбар	100	3
143	Завхан	Улиастай	Биндэр-хайрхан	100	2
144	Завхан	Эрдэнэ-хайрхан	Хайрхан УУГ	100	7
146	Орхон	Орхон	Ноён төв	100	16
148	Орхон	Орхон	Хээлэл мэдээллийн төв	100	15
151	Орхон	Орхон	Ой, ангийн аж ахуй	100	7
152	Орхон	Орхон	Тээвэр зохицуулах алба	100	7
153	Орхон	Орхон	Харгалантын орон сууцны алба	100	6
154	Орхон	Орхон	ХАА-н даатгал	100	3
155	Өвөрхангай	Арвайхээр	Мал, түүхий эд бэлтгэлийн газар	100	27
158	Өвөрхангай	Арвайхээр	Монгол даатгал салбар	100	11
160	Өвөрхангай	Арвайхээр	Хөдөлмөрийн төлөө сонин	100	6
161	Өвөрхангай	Арвайхээр	ХАА-н даатгал компани	100	3
166	Өмнөговь	Даланзадгад	Монгол даатгал компанийн салбар	100	5
170	Өмнөговь	Цогтцэций	Эрчим хүчний салбар	100	13
172	Сүхбаатар	Асгат	Алдрин овоо компани	100	4
174	Сүхбаатар	Баруунурт	Монгол Даатгал компанийн		

			салбар	100	30
175	Сүхбаатар	Баруун-урт	Хөргуй компани	100	18
176	Сүхбаатар	Баруун-урт	Байгалийн засал компани	100	18
177	Сүхбаатар	Баруун-урт	ХАА-н даатгалын салбар	100	14
178	Сүхбаатар	Баруун-урт	Тээврийн хяналт зохицуулалтын газар	100	10
180	Сүхбаатар	Баруун-урт	Хөвчлэл мэдээллийн алба	100	6
182	Сүхбаатар	Баруун-урт	Кино театр	100	5
186	Сэлэнгэ	Алтанбулаг	Төгсгөөбулаг УУГ	100	12
187	Сэлэнгэ	Баруун-бүрэн	Нийтлэг үйлчилгээний алба	100	14
188	Сэлэнгэ	Банкгол	Усан хангамж УУГ	100	23
190	Сэлэнгэ	Жавхлалт	Үндраа УУГ	100	4
191	Сэлэнгэ	Мандал	ОА аж ахуй	100	44
192	Сэлэнгэ	Мандал	Чандмань эрдэнэ УУГ	100	17
194	Сэлэнгэ	Орхон	Орхонгөрөл УУГ	100	5
195	Сэлэнгэ	Орхонтуул	Туул УУГ	100	14
196	Сэлэнгэ	Сайхан	Хөтөл ОСА контор	100	40
198	Сэлэнгэ	Сайхан	Ус суваг УУГ	100	8
199	Сэлэнгэ	Сүхбаатар	ОА, АН ТӨБ	100	35
200	Сэлэнгэ	Сүхбаатар	Барилга захирагчийн товчоо	100	13
202	Сэлэнгэ	Сүхбаатар	Нүүрс борлуулах цэг	100	10
203	Сэлэнгэ	Сүхбаатар	Монгол даатгал компанийн салбар	100	9

205	Сэлэнгэ	Сүхбаатар	ХАА-н даатгал	100	3
207	Сэлэнгэ	Хүдэр	Ус суваг УҮГ	100	13
208	Сэлэнгэ	Хүдэр	Нвээл	100	9
209	Сэлэнгэ	Цагаан-нуур	Жаргалант УҮГ	100	22
210	Сэлэнгэ	Цагаан-нуур	Хангай УҮГ	100	3
212	Сэлэнгэ	Баянмар	Илч УҮГ	100	16
214	Төв	Аргалант	Аргалант эрчим УҮГ	100	35
215	Төв	Батсүмбэр	Ойн анги	100	30
216	Төв	Баян	Эрчимт УҮГ	100	14
217	Төв	Баян-цагаан	Жаргалант УҮГ	100	1
218	Төв	Баянцогт	Буянт УҮГ	100	18
219	Төв	Баянчандмань	Таван-эрдэнэ	100	4
220	Төв	Борнуур	Тулга УҮГ	100	25
221	Төв	Бүрэн	Бүрэн сумын Бадрах УҮГ	100	6
222	Төв	Дэлгэрхаан	Дэлгэрхаан Дэлгэр УҮГ	100	5
223	Төв	Жаргалант	Гал УҮГ	100	24
224	Төв	Залмар	Хайлаас-тайн ам компани	100	13
225	Төв	Зуунмод	Зуунмод Хот тохижилтын газар	100	35
226	Төв	Зуунмод	Барилга захиалагчийн товчоо	100	4
228	Төв	Лүн	Дулаанм зуух	100	14
229	Төв	Өндөр-ширээт	Дөл компани	100	13
230	Төв	Төв	Ой, ангийн аж ахуй	100	10
231	Төв	Төв	ХАА-н даатгал	100	3
232	Төв	Угтаал	Чандмань эрдэнэ	100	19
233	Төв	Цээл	Чандмань эрдэнэ УҮГ	100	21

235	Төв	Эрдэнэ	Тулга УҮГ /дулаана/	100	5
236	Төв	Эрдэнэ- саят	Илч УҮГ	100	20
237	Төв	Эрдэнэ- саят	Бадми гол	100	0
238	Увс	Баруун- туруун	Эрчим хүч УҮГ	100	10
244	Увс	Улаангом	ХАА-н даатгал	100	10
245	Увс	Улаангом	Ой, ангийн аж ахуй	100	8
246	Увс	Улаангом	Мал, түү- хийн эд бэлтгэлийн газар	100	6
303	Улаан- баатар	Сүхбаатар	Ардын эрх сонин	100	50
308	Улаан- баатар	Сүхбаатар	БҮГДХ	100	26
311	Улаан- баатар	Сүхбаатар	Улсын гэр- лэл зур- гийн газар	100	21
361	Ховд	Алтай	Угалз компани	100	15
362	Ховд	Булган	Булган сервис компани	100	5
363	Ховд	Дуут	Зочил буудал	100	5
365	Ховд	Жаргалан	"Дол" компани	100	20
370	Ховд	Жаргалан	Хот тохи- жилт	100	10
372	Ховд	Жаргалан	Барлаг	100	7
373	Ховд	Жаргалан	Монгол даатгал	100	6
374	Ховд	Жаргалан	Түлэний аж ахуй	100	5
376	Ховд	Жаргалан	Сутай	100	3
377	Ховд	Зэрэг	Алтангур- гөлдэй компани	100	7
378	Ховд	Төвч	Нийтийн үйлчилгээ- ний алба	100	6
381	Хөвсгөл	Мөрөн	Хот бай- гуулалт /үйн.төв/	100	20

382	Хөвсгөл	Мөрөн	Монгол даатгал компани	100	10
385	Хөвсгөл	Мөрөн	Хүнс, ХАА-н даатгал	100	7
386	Хөвсгөл	Мөрөн	"Эрх чөлөө" сонним редакци	100	7
387	Хөвсгөл	Мөрөн	Радио редакци	100	5
388	Хөвсгөл	Мөрөн	Телевизиан "Солонго" нэгдэл	100	5
391	Хөвсгөл	Хатгал	Тохижилт үйлчилгээний төв	100	8
398	Хэнтий	Баян-адарга	Баян-адарга цахилгаан эрчим хүч	100	3
399	Хэнтий	Биндэр	Биндэрийн ой аж ахуй	100	14
400	Хэнтий	Гурван-баян	Дизель станц	100	6
403	Хэнтий	Хэрлэн	Харгуу компани	100	40
404	Хэнтий	Хэрлэн	Ус суваг, орон сууц ашиглалтын газар	100	36
406	Хэнтий	Хэрлэн	Монгол эмнэлэг	100	17
407	Хэнтий	Хэрлэн	Мал, түүхий эд бэлтгэлийн газар	100	15
410	Хэнтий	Хэрлэн	Тээврийн хяналт зохицуулалтын хэсэг	100	10
412	Хэнтий	Хэрлэн	Хот тохижилт, үйлчилгээний хэсэг	100	8
413	Хэнтий	Хэрлэн	Монгол даатгал		

			компани	100	7
14	Хэнтий	Хэрлэн	Ой, ан төв	100	4
15	Хэнтий	Хэрлэн	"Урагшаа" сонин газар	100	3
16	Хэнтий	Хэрлэн	ХАА-н даатгал	100	3

ГУРАВ. Хувьчлах томоохон аж ахуйн нэгжүүд

/2 дугаар жагсаалт/

А. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд

д	Аймаг, нийслэ- лийн нэр	Сум, дүүргийн нэр	Байгуул- лагын нэр	Төрийн өмчийн эзлэх хувь	Ажил- лагч- дмн тоо
2	Өвөр- хангай	Хархорин	Ган тээрэм ХК	60	123
6	Төв	Сүмбэр	Сүмбэр Өлзий ХК	52	57
10	Улаан- баатар	Сүхбаатар	Эмнэлгийн техник ком- пани ХК	51	160

В. Улсын үйлдвэрийн газрууд

д	Аймаг, нийслэ- лийн нэр	Сум, дүүргийн нэр	Байгуул- лагын нэр	Төрийн өмчийн эзлэх хувь	Ажил- лагч- дмн тоо
	Архангай	Эрдэнэ- булган	Геологийн анги	100	114
	Баянхонгор	Баянхонгор	Хот тохи- жилт, үйл- чилгээний алба	100	52
2	Дархан-уул	Дархан-уул	ОСА 3 ду- гаар ком- пани	100	94
3	Дархан-уул	Дархан-уул	ОСА 2 ду- гаар ком- пани	100	89
4	Дархан-уул	Дархан-уул	ОСА 1 дү- гээр ком- пани	100	72
7	Дорноговь	Сайншанд	ОСНААГ	100	73

18	Дорнод	Хэрлэн	Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар	100	228
19	Дундговь	Мандалговь	Ус суваг, орон сууц ашиглалтын газар	100	83
20	Завхан	Улиастай	НҮ газар	100	65
23	Орхон	Орхон	ОСНАА газар	100	160
30	Өвөрхангай	Хархорин	Илч УУГ	100	113
37	Сэлэнгэ	Сүхбаатар	Урсгал УУГ	100	195
38	Төв	Заамар	Заамар эрчим УУГ	100	61
41	Увс	Улаангом	Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар	100	110
52	Улаанбаатар	Баянгол	Улаанбаатар хот орчмын зам засвар, ашиглалт, хангамж компани	100	120
56	Улаанбаатар	Баянзүрх	Автобус-3 компани	100	208
66	Улаанбаатар	Сонгинохайрхан	Цахилгаан тээвэр компани	100	995
67	Улаанбаатар	Сонгинохайрхан	Автобус-2 компани	100	819
79	Улаанбаатар	Сүхбаатар	Иргэдийг үйлчлэх Були компани	100	340
80	Улаанбаатар	Сүхбаатар	Залаат компани	100	198
81	Улаанбаатар	Сүхбаатар	Авто тээврийн газар	100	167
85	Улаанбаатар	Сүхбаатар	Хотын тээврийн газар	100	103
86	Улаанбаатар	Сүхбаатар	Гэрлэх ёслолын ордон	100	97
87	Улаанбаатар	Сүхбаатар	Соймбо хэвлэлийн компани	100	94
90	Улаанбаатар	Сүхбаатар	Үнэт цаас		

	баатар		компани	100	65
102	Улаан-баатар	Хан-уул	Нүхт компани	100	70
118	Ховд	Жаргалан	ОСНАА контор	100	86
120	Хөвсгөл	Мөрөн	ОСНАА компани	100	86

Засгийн газрын 1997 оны 229 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

"ТӨРИЙН ӨМЧИЙГ 1997-2000 ОНД ХУВЬЧЛАХ ХӨТӨЛВӨР"-ИЙН ХУВЬЧЛАХ ЖИЖИГ ВОЛОН ТОМООХОН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТАД НЭМИ ОРУУЛАХ АЖ АХУЙН НЭГЖҮҮД

ХОЁР.Хувьчлах жижиг аж ахуйн нэгжүүд

/1 дүгээр жагсаалт/

А.Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд

1/д	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Төрийн өмчийн эзлэх хувь	Ажиллагчдын тоо
61	Төв	Сүмбэр	Сүмбэр Өлзий ХХ	52	49
62	Улаан-баатар	Сүхбаатар	Эмнэлгийн техник компани ХХ	51	25
63	Ховд	Жаргалан	Алтайн эм ХХ	51	8

Б.Улсын үйлдвэрийн газрууд

1/д	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Төрийн өмчийн эзлэх хувь	Ажиллагчдын тоо
17	Архангай	Эрдэнэ-булган	Геологийн анги	100	1
18	Улаан-баатар	Сүхбаатар	Иргэдийг үйлчлэх Були		

			компани	100	33
419	Улаан-баатар	Сүхбаатар	Залаат компани	100	12
420	Улаан-баатар	Сүхбаатар	Соёмбо хэвлэлийн компани	100	20
421	Улаан-баатар	Сүхбаатар	Үнэт цаас компани	100	39
422	Улаан-баатар	Хан-уул	Нүхт компани	100	48
423	Төв	Борнуур	Дуган хадны амралт	100	5

ГУРАВ.Хувьчлах томоохон аж ахуйн нэгжүүд

/2 дугаар жагсаалт/

Б.Улсын үйлдвэрийн газрууд

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Төрийн өмчийн эзлэх хувь	Ажиллагчдын тоо
	Өвөрхангай	Хархорин	Баруун чиглэлийн зам барилгын трест	100	104

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1997 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Дугаар 230

Улаанбаатар хот

С.Магсаржавын ойг тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Ардын Хатанбаатар Сандагдоржийн Магсаржавын мэндэлсний 120 жилийн ойг 1998 оны 6 дугаар сард ёслол тэмдэглэх талаар Батлан хамгаалах яам, Булган аймгийн Засаг даргаас тавьсан саналыг дэмжсүгэй.

2. Ардын Хатанбаатар С.Магсаржавын мөндөлсний 20 жилийн ойг ёслол тэмдэглэхэд зориулан 10,0 арван) сая төгрөгийг Засгийн газрын нөөцөөс тухайн ед нь гаргахыг Сангийн сайд П.Цагаанд зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд	М.ЭНХСАЙХАН
Батлан хамгаалахын сайд	Д.ДОРЛИГЖАВ
Сангийн сайд	П.ЦАГААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1997 оны 12 дугаар Улаанбаатар
сарын 3-ны өдөр Дугаар 233 хот

Тогтоолын заалтад өөрчлөлт
оруулах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг аргын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ОГТООХ нь:

“Эрчим хүчний хангамжийг сайжруулах зарим арга эмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 1997 оны дугаар сарын 14-ний өдрийн 120 дугаар тогтоолын дүгээр зүйлийн “. . . Налайхын дулааны станцыг нийслэлийн Засаг даргын мэдэлд тус тус . . .” гэсэн эсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд	М.ЭНХСАЙХАН
Дэд бүтцийн хөгжлийн сайд	Г.НЯМДАВАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1997 оны 12 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 234

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

“Ашигт малтмалын тухай хуулийг дагах мөрдөх журмы тухай Монгол Улсын хууль”-ийн 7 дугаар зүйлий үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлы зардлын хэмжээг шинэчлэн тогтоох, төсөвт нөхөн төлө журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. “Төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлы зардлын хэмжээг шинэчлэн тогтоох, төсөвт нөхөн төлө журам”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахы Сангийн сайд П.Цагаан, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сай Л.Нямсамбуу нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Жура батлах тухай” Засгийн газрын 1995 оны 2 дугаар сары 22-ны өдрийн 28 дугаар тогтоолыг хүчингүй болсон тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М. ЗИХСАЙХАН

Сангийн сайд

П. ЦАГААН

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд

Л. НИЯМСАМБУУ

Засгийн газрын 1997 оны 23
дүгээр тогтоолын хавсралт

**ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙСЭН ХАЙГУУЛЫН
АЖЛЫН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ,
ТӨСӨВТ НӨХӨН ТӨЛӨХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын төсвийн хөрөнгөөр геологи, хайгуулы ажил нь хийгдсэн ашигт малтмалын орд газрыг ашиглы лиценз эзэмшигч хуулийн этгээд хайгуулын зардлы

син төвлөрсөн төсөвт нөхөн төлөхөд энэхүү журмыг рленэ.

1.2. Энэхүү журамд хуулийн этгээд өмчийн хэлбэр ггалзахгүйгээр хамрагдана.

ХОЁР. Хайгуулын ажлын зардлыг шинэчлэн тогтоох аргачлал

2.1. Төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын йланд тусгагдсан геологк хайгуулын ажлын зардал нь сөвт нөхөн төлөх үеийн шинэчилсэн зардлыг /цаалид хөн төлбөр гэнэ/ тогтоох үндэс болно.

2.2. Засгийн газрын 1991 оны 20 дугаар тогтоолыг цэслэн 1991 оноос өмнөх хугацаанд төсвийн хөрөнгөөр йсэн хайгуулын ажлын анхны зардлын цалинг 2 дахин, сад материаллаг зардлыг 1,75 дахин нэмэгдүүлж цно.

2.3. Хайгуулын ажлын ажлын зардлын доторхи цалинг йт зардлын 25 хувиар, материаллаг зардлыг 75 хувиар цож дараахь байдлаар хайгуулын ажлын зардлыг 1991 м 1 дүгээр сарын 16-ны түвшинд шинэчлэн тогтооно.

$ХАЭЗ^{1991} = /ХААЗ * 0,25 * 2 + /ХААЗ * 0,75 * 1,75/$

ХАЭЗ¹⁹⁹¹ - Засгийн газрын 1991 оны 20 дугаар тогтоолын суу 1991 оны түвшинд шинэчлэн тогтоосон хайгуулын цны шинэчилсэн зардал /ХАЭЗ/.

ХААЗ - Хайгуулын ажлын анхны /ХААЗ/ нийт зардал.

2.4. Энэ журмын 2.3-т заасан аргачлалын дагуу цсон зардлыг 1991 оны 1 дүгээр сарын 16-наас йххи валютын ханшны өөрчлөлтийн итгэлдүүрээр күүлэн хайгуулын ажлын шинэчилсэн зардлыг /ХАЭЗ/ цно. Валютын ханшны өөрчлөлтийн итгэлдүүрийг цохдоо төлбөр хийх тухайн өдрийн Монгол банкны лласан албан ёсны ханшигт үндэслэнэ.

2.5. Ордны нөөцийг бүрэн ашиглахгүд, мөн нэг ордон 1 хэдэн хуулийн этгээд олборлолт явуулах тохиолдолд төбөрийг олборлох нөөцийн хэмжээнд харгалзуулан цлуулна.

ГУРАВ. Хайгуулын ажлын зардлыг төсөвт нөхөн төлөх

3.1. Нөхөн төлбөрийг ашигт малтмалын орд эзэмшигч /лийн этгээд нь "Ашигт малтмалын тухай хуулийг цж мөрдөх журмын тухай Монгол Улсын хууль"-ийн 7

дугаар зүйлийн дагуу 5 жилд тэнцүү хэмжээгээр хувааж төлнө.

3.2. Ашигт малтмал ашиглах лиценз эзэмшигч хуулийн этгээд нь нөхөн төлбөрийг эхний жилд бүрэн төлж болно.

3.3. 1990 оноос өмнө ашиглалт явуулсан ордны хайгуулын ажлын нөхөн төлбөрийг тухайн ордны 1991 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар тооцсон нөөцийн хөдөлгөөний үлдэгдэл нөөцөд үндэслэн энэхүү журмыг баримтлан тогтооно.

3.4. Ашигт малтмалын орд ашиглах лиценз эзэмшигч нь хайгуулын ажлын нөхөн төлбөрийг тухайн жилийн нягтлан бодох бүртгэлийн тайлан гаргахдаа зардалд оруулж тооцно.

3.5. Төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ашигт малтмалын орд ашиглах лиценз эзэмшигч нь энэ журмыг үндэслэн Ашигт малтмалын хэрэг эрхлэх газартай гэрээ байгуулж нөхөн төлбөрийг Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын дансанд оруулж уг газарт тайлагнан тооцоо хийнэ.

3.6. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар өөрийн дансанд орсон нөхөн төлбөрийн орлогыг ажлын 3 хоногт багтаан төвлөрсөн төсвийн дансанд шилжүүлнэ.

3.7. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар тухайн улирлын төлбөрийн байдлын мэдээг дараа сарын 3-н дотор, жилийн тайлангаа дараа жилийн 2 дугаар сарын 20-н дотор Сангийн яаманд албан ёсоор оруулж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 12 дүгээр		Улаанбаатар
сарын 3-н өдөр	Дугаар 235	хот

Нүүрсний уурхайнуудын лицензийг шинэчлэн олгох тухай

Эрчим хүчний тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 7, 15 дугаар зүйлийн 7 дахь заалтуудыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улс, бүс нутгийн эдийн засгийн асуулгүй байдал, хүн амын хэвийн амьдралын нөхцөлийг хангахад гүйцэтгэх үүргийг харгалзан хавсралтад дурьдсан нэг бүхий 18 аж ахуйн нэгжийн эзэмшиж буй нүүрсний ор:

шиглах лицензийг 1997 оны 12 дугаар сард багтаан шинэчлэн олгох арга хэмжээ авахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Л.Нямсамбууд зөвшөөрсүгэй.

2. Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажилд ариуцлагагүй хандсан төрийн өмчийн болон төрийн мчийн оролцоотой нүүрсний уурхайнуудын удирдлагатай охих хариуцлага тооцохыг Дэд бүтцийн хөгжлийн сайд .Нямдаваа, Сангийн сайд П.Цагаан нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд	М.Энхсайхан
Сангийн сайд	П.Цагаан
Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд	Л.Нямсамбуу
Дэд бүтцийн хөгжлийн сайд	Г.Нямдаваа

Засгийн газрын 1997 оны 235
дугаар тогтоолын хавсралт

ЛИЦЕНЗ ШИНЭЧЛЭН ОЛГОХ НҮҮРСНИЙ
УУРХАЙНУУДЫН ЯАГСААЛТ

Аж ахуйн нэгжийн нэр	Ордын нэр, байршил	Эзэмших буй тусгай зөвшөөрлийн дугаар
Багануур ХК	Багануур, Багануур дүүрэг	003
Шарын гол ХК	Шарын гол, Дархан-уул аймаг	027
Адуунчулуун ХК	Адуунчулуун, Дорнод аймаг,	029
Талын гал ХК	Талбулаг, Сүхбаатар аймаг	030
Чандгатцайдам УҮГ	Чандган тал, Хэнтий аймаг	031
Тэвшийн говь ХК	Тэвшийн говь, Дундговь аймаг	033
Жинст ХК	Жинст, Баянхонгор аймаг	036

8.	Хөшөөт УУГ	Хөшөөт, аймаг	Ховд	037
9.	Хартарвагатай ХК	Хартарвагатай, Увс аймаг		038
10.	Нүүрсхотгор ХК	Нүүрсхотгор, аймаг	Увс	039
11.	Могойнгол ХК	Могойнгол, Хөвсгөл аймаг		040
12.	Сайхан-овоо УУГ	Сайхан-овоо, Булган аймаг		041
13.	Шивээ-овоо ХК	Шивээ-овоо, Говьсүмбэр аймаг		042
14.	Түлш-алтай ХХК	Зээгт, аймаг	Говь-Алтай	035
15.	Карьерын аж ахуй УУГ	Хамарин Дорноговь аймаг	хурал,	217
16.	ШШБЕГ-ин Монфем УУГ	Налайх, Налайх дүүрэг		196
17.	Налайх-өргөө ХК	Налайх, Налайх дүүрэг		197
18.	УУА алба УУГ	Налайх, Налайх дүүрэг		118

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Л. Цог
Хариуцлагатай нарийн бичгийн дарга	Б. Ганбат
Гишүүд:	Б. Баламханд Ч. Дашийм Б. Цэнддоо Б. Чимол Б. Энэбиш
Техник редактор	С. Итгэлт
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан Б. Явжигдхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1997 оны 12-р сарын 20-нд
Өрөлтөд 1997 оны 12-р сарын 20-нд Хэвлэлтэд
1997 оны 12-р сарын 24-нд Хэвлэлийн хуудас 6,5.
Хэвлэсэн тоо 4086 ш

Манай хаяг: Улаанбаатар-12
Төрийн ордон Утас 322838

Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг
Эрхлэх Газрын харьяа
Хэвлэх үйлдвэр